

“МОНГОЛ УЛСАД ӨРНӨЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БУЙ БАЙДАЛ”

социологийн судалгааны тайлан



ХАННС

ЗАЙДЕЛИЙН

САН



“ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ”
АКАДЕМИ

Улаанбаатар

2007

“AKZEPTANZ VON RECHT IM REFORMPROZESS DER MONGOLEI”

*Untersuchung über das Rechtsbewusstsein
der Bevölkerung in der Mongolei*



HANNS
SEIDEL
STIFTUNG



AKADEMIE
“RECHTSBILDUNG”

Ulaanbaatar

2007

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	4
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	6
ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	9
БҮЛЭГ I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ	10
БҮЛЭГ II. “МОНГОЛ УЛСАД ӨРНӨЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БУЙ БАЙДАЛ” СОЦИОЛОГИЙН СУДАЛГААНД ОРОЛЦСОН ИРГЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	13
БҮЛЭГ III. “МОНГОЛ УЛСАД ӨРНӨЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БУЙ БАЙДАЛ” СОЦИОЛОГИЙН СУДАЛГААНД ОРОЛЦСОН ХУУЛИЙН САЛБАРТ АЖИЛЛАГСДЫН МЭДЭЭЛЭЛ	20
БҮЛЭГ IV. “МОНГОЛ УЛСАД ӨРНӨЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БУЙ БАЙДАЛ” СОЦИОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН (иргэдээс авсан судалгаа)	26
БҮЛЭГ V. “МОНГОЛ УЛСАД ӨРНӨЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БУЙ БАЙДАЛ” СОЦИОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН (хуулийн салбарт ажиллагсдаас авсан судалгаа)	38
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	52

ӨМНӨХ ҮГ

1990 оноос өмнө манай улсад эрүү, иргэн, хөдөлмөр, гэр бүлийн харилцааг голчлон зохицуулдаг 50 хүрэхгүй хууль болон захиргааны байгууллагаас баталсан хуульчилсан актуудаар нийгмийн дийлэнх харилцааг зохицуулдаг байв.

1992 онд батлагдсан Монгол Улсын ардчилсан Үндсэн хууль нь эрх зүйт төрийг жинхэнэ утгаар нь төлөвшүүлэх үндэс суурь, эрх зүйн шинэтгэлийг дэс дараатай, тасралтгүй хэрэгжүүлэх эх сурвалж болсон юм. Үндсэн хуультай хамт түүний нэгэн адил хүчинтэй “Үндсэн хуулийн хавсралт хууль”-ийг батлан гаргасан бөгөөд түүнд БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих арга замыг, өөрөөр хэлбэл, өргөн утгаар нь эрх зүйн хуучин тогтолцоог бүрэн халж, хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлж шинэчлэхийг гол болгон заасан. Үүгээр эрх зүйг бүхэлд нь шинэтгэх үйл явц эхэлсэн юм.

Өнөөдрийн байдлаар манай улсын хэмжээнд 360 гаруй төрөлжсөн хууль хүчин төгөлдөр үйлчилж, нийгмийн харилцааг зохицуулж байна.

Монгол Улсын шинэ ардчилсан Үндсэн хууль батлагдаад даруй 14 жил болж байна. Нийгмийн харилцаа энэ Үндсэн хуулийн үзэл санааны дагуу төлөвшиж, эрх зүйн шинэ тогтолцоо үндсэндээ бүрдэж байна.

Хэт төвлөн удирдах ёсноос иргэний нийгэмд шилжих шилжилт нь тийм ч амар хялбар байхгүй бөгөөд тэр тусмаа нийт иргэддээ эрх зүйн боловсрол мэдлэг олгохгүйгээр уг шилжилтийг хэрэгжүүлэх гэж оролдох нь үр дүнгүй гэдэг нь манай улсын сүүлийн хэдэн жилийн туршлагаас тодорхой харагдах боллоо. Иргэний ардчилсан нийгмийг иргэдийн өөрсдийн сайн дурын ухамсарт оролцоогүйгээр төсөөлөх аргагүй.

Энэ ч үүднээс тус академи ХБНГУ-ын Ханнс- Зайделийн сангийн дэмжлэгтэйгээр иргэдийн болон хуульчдын дунд Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийг хүлээн зөвшөөрч буй талаар социологийн судалгааг 2005- аас 2006 оны хооронд явуулсан билээ.

Ханнс- Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академиас гадаад дотоодын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, судлаач эрдэмтэн, оюутан, сонирхсон хувь хүнд зориулан гаргаж буй энэхүү судалгааны тайлан УИХ-аас 1998 оны 1-р сард батлагдсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэх үйл явцад ач холбогдлоо өгнө гэдэгт бид эргэлзэхгүй байна.

Энэхүү судалгааг амжилттай хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх, асуулт боловсруулах зэргээр бүх талын туслалцаа үзүүлсэн доктор, проф. Х. Шоллер, В. Ланге нарт болон судалгааны тайлан бичиж гүйцэтгэсэн ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны сургуулийн Философи, соёл судлалын профессоровын багийн багш, судлаач А.Энхбатад гүн талархалаа илэрхийлж байна.

**Ханнс- Зайделийн сангийн
Монгол дахь төлөөлөгчийн газар,**

“Эрх зүйн боловсрол” академи

VORWORT

Bis 1990 wurden die straf-, zivil-, arbeits- und familienrechtlichen Beziehungen von nicht einmal 50 Hauptgesetzen und die meiste gesellschaftlichen Beziehungen durch gesetzliche Akten, herausgegeben von Verwaltungsorganen, geregelt.

Die in 1992 verabschiedete demokratische Verfassung der Mongolei ist als Grundlage für die Bildung eines Rechtsstaates und die beständige, konsequente Fortführung der Rechtsreformen anzusehen. In dem mit der Verfassung gleichzeitig herausgegebenen und gleichsam gültigen Gesetz “Anlage zu der Verfassung”, wurde vorgegeben, wie der Übergang von der Verfassung der MVR zu der Verfassung der Mongolei anzugehen ist. Es wurde, anderen Worten, die Absage an das alte Rechtssystem und die Erneuerung der Gesetzgebungen, gemessen an der Verfassung der Mongolei deklariert. Somit begann der umfassende Erneuerungs /Reform/- prozess des Rechtswesens.

Zum heutigen Zeitpunkt gelten zur Regelung der gesellschaftlichen Beziehungen in unserem Land über 360 spezialisierte Gesetze.

Es sind nunmehr 15 Jahre seit der Verabschiedung der neuen, demokratischen Verfassung vergangen. Die gesellschaftlichen Beziehungen haben sich nach dem Konzept dieser Verfassung weitgehend etabliert und das neue Rechtssystem hauptsächlich gebildet.

Aus den Erfahrungen unseres Landes während der letzten Jahre hat sich deutlich herausgestellt, dass der Übergang von einer zentralisiert gesteuerten zu einer bürgerlichen Gesellschaft nicht einfach ist und dies ohne die Vermittlung von Rechtskenntnissen an die Bürger zu keinem Ergebnis führt. Eine bürgerliche, demokratische Gesellschaft ist ohne freiwillige, bewusste Eigenteilnahme der Bürger undenkbar.

Aus diesem Grund hat die Akademie mit Unterstützung der Hanns-Seidel-Stiftung unter Bürgern und Juristen statistische Untersuchungen zu der Akzeptanz von Recht im Reformprozess der Mongolei im Zeitraum 2005-2006 durchgeführt.

Wir sind zuversichtlich, dass dieser Forschungsbericht, gerichtet an aus- und inländische Wissenschafts- und Forschungseinrichtungen, Wissenschaftler und Forscher, Studenten und weitere Interessenten, ein Beitrag zur erfolgreichen Umsetzung des im Januar 1998 verabschiedeten “Programms der Rechtsreformen in der Mongolei” sein wird.

Vielen Dank an Herrn Prof. Dr. H.Scholler und Herrn W.Lange, die die erfolgreiche Umsetzung dieser Untersuchung durch Beratungen und Ausarbeitung von Fragebögen unterstützten und Herrn A.Enkhbat, Forscher und Lehrkraft des Teams des Professors für Philosophie und Kulturforschung des Instituts für Geisteswissenschaften an der Universität für Wissenschaft und Technik für die schriftliche Ausführung des Untersuchungsberichts.

**Das Projektbüro der
Hanns-Seidel-Stiftung in der Mongolei,**

Akademie “Rechtsbildung”

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	Хот, аймгуудаас судалгаанд хамрагдсан иргэдийн тоо, хувь
Хүснэгт 1.2	Судалгаанд оролцогчдын нас
Хүснэгт 1.3	Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал
Хүснэгт 1.4	Судалгаанд оролцогчдын ерөнхий боловсролын түвшин
Хүснэгт 1.5	Ерөнхий боловсролын сургууль төгссөн он, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.6	Мэргэжлийн боловсрол, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.7	Их, дээд сургуулийн чиглэл, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.8	Судалгаанд оролцогчдын их, дээд сургууль төгссөн статус
Хүснэгт 1.9	Судалгаанд оролцогчдын эрдмийн зэрэг, цол
Хүснэгт 1.10	Судалгаанд оролцогчдын мэргэжил
Хүснэгт 1.11	Судалгаанд оролцогчдын эрхэлдэг ажил
Хүснэгт 1.12	Ам бүлийн тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.13	Судалгаанд оролцогчдод радио байдаг эсэх
Хүснэгт 1.14	Судалгаанд оролцогчдод телевиз байдаг эсэх
Хүснэгт 1.15	Судалгаанд оролцогчдод интернет байдаг эсэх
Хүснэгт 1.16	Өрхийн жилийн орлого, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.17	Нийт малын тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.18	Адууны тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.19	Хонины тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.20	Ямааны тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.21	Тэмээний тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 1.22	Үхрийн тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.1	Хот, аймгуудаас судалгаанд хамрагдсан иргэдийн тоо, хувь
Хүснэгт 2.2	Судалгаанд оролцогчдын нас
Хүснэгт 2.3	Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал
Хүснэгт 2.4	Судалгаанд оролцогчдын ерөнхий боловсролын түвшин
Хүснэгт 2.5	Ерөнхий боловсролын сургууль төгссөн он, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.6	Мэргэжлийн боловсрол, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.7	Их, дээд сургуулийн чиглэл, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.8	Судалгаанд оролцогчдын их, дээд сургууль төгссөн статус
Хүснэгт 2.9	Судалгаанд оролцогчдын эрдмийн зэрэг, цол
Хүснэгт 2.10	Судалгаанд оролцогчдын мэргэжил
Хүснэгт 2.11	Судалгаанд оролцогчдын эрхэлдэг ажил
Хүснэгт 2.12	Ам бүлийн тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.13	Судалгаанд оролцогчдод радио байдаг эсэх
Хүснэгт 2.14	Судалгаанд оролцогчдод телевиз байдаг эсэх
Хүснэгт 2.15	Судалгаанд оролцогчдод интернет байдаг эсэх
Хүснэгт 2.16	Өрхийн жилийн орлого, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.17	Нийт малын тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.18	Адууны тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.19	Хонины тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.20	Ямааны тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.21	Тэмээний тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 2.22	Үхрийн тоо, бүлэглэсэн байдлаар
Хүснэгт 3.1	Эрх зүйн дутагдалтай байдал, шударга бус байдлыг юунаас үүдэлтэйг хариулсан байдал
Хүснэгт 3.2	Өөрчлөх, хүчингүй болгох хуулийн жагсаалт

- Хүснэгт 3.3 Монголын ард түмний амьдрал сайжрахад сайн хуулиуд нэмэр болох уу?
- Хүснэгт 3.4 Танд эрх зүйн болон хуулийн зөвлөгөө хэрэгтэй юу?
- Хүснэгт 3.5 Захиргааны байгууллагын шийдвэрт та гомдол гаргаж байсан уу?
- Хүснэгт 3.6 Гомдол гаргаж байсан байгууллагуудын нэр
- Хүснэгт 3.7 Гомдол гаргасан иргэдийн амжилт олсон байдал
- Хүснэгт 3.8 Шүүхээр асуудал шийдүүлж байсан байдал
- Хүснэгт 3.9 УИХ дахь өөрийн сонгосон төлөөлөгчдөө сэтгэл хангалуун байдаг эсэх
- Хүснэгт 3.10 УИХ-аас иргэдийн сэтгэлд нийцдэггүй хууль батлан гаргадаг эсэх
- Хүснэгт 3.11 УИХ буюу УИХ-ын гишүүд бидэнд үүрэг ногдуулахаас бус бидний эрхийн талаар санаа тавьдаггүй
- Хүснэгт 3.12 УИХ-ын гишүүд жирийн иргэдийн бодол санаа, хүсэл зоригт их анхаарал тавьдаг
- Хүснэгт 3.13 Хууль хэрхэн батлагдан гарсныг жирийн иргэд ойлгодоггүй
- Хүснэгт 3.14 Эрх зүйн тогтолцоо тодорхой ач холбогдолтой байх талаар төрийн зүгээс их анхаардаг
- Хүснэгт 3.15 Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтууд
- Хүснэгт 3.16 Нийгэм, улс төрийн идэвхийг дүгнэсэн байдал
- Хүснэгт 3.17 УИХ-ын сонгууль
- Хүснэгт 3.18 УИХ-ын сонгуульд оролцсон иргэдийн санал өгсөн байдал
- Хүснэгт 3.19 Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон байдал
- Хүснэгт 3.20 Орон нутгийн сонгуульд оролцсон байдал
- Хүснэгт 4.1 Хуулиудад өөрчлөлт орсныг мэддэг байдал
- Хүснэгт 4.2 Эрх зүйн дутагдалтай байдал, шударга бус байдлыг юунаас үүдэлтэйг хариулсан байдал
- Хүснэгт 4.3 Өөрчлөх, бүр байхгүй болгох хуулийн жагсаалт
- Хүснэгт 4.4 Сайжруулах шаардлагатай хуулиуд, эрх зүйн салбарыг нэрлэсэн байдал
- Хүснэгт 4.5 Танд эрх зүйн болон хуулийн зөвлөгөө хэрэгтэй юу?
- Хүснэгт 4.6 Захиргааны байгууллагын шийдвэрт та гомдол гаргаж байсан уу?
- Хүснэгт 4.7 Гомдол гаргаж байсан захиргааны байгууллагын шийдвэр
- Хүснэгт 4.8 Гомдол гаргаад амжилт олсон байдал
- Хүснэгт 4.9 Та өөрт холбогдох ямар нэг асуудлыг шүүхээр шийдвэрлүүлж байсан уу?
- Хүснэгт 4.10 Би УИХ дахь өөрийн сонгосон төлөөлөгчдөө сэтгэл хангалуун байдаг
- Хүснэгт 4.11 УИХ-аас иргэдийн сэтгэлд нийцдэггүй хууль батлан гаргадаг
- Хүснэгт 4.12 УИХ буюу УИХ-ын гишүүд бидэнд үүрэг ногдуулахаас бус бидний эрхийн талаар санаа тавьдаггүй
- Хүснэгт 4.13 УИХ-ын гишүүд жирийн иргэдийн бодол санаа, хүсэл зоригт их анхаарал тавьдаг.
- Хүснэгт 4.14 Хууль хэрхэн батлагдан гарсныг жирийн иргэд ойлгодоггүй
- Хүснэгт 4.15 Монгол Улсын эрх зүйн бүтцийг би дараахь байдлаар тодорхойлж чадна. Би ч гэсэн хуулийг яг адилханаар батлан гаргах байсан

- Хүснэгт 4.16 Эрх зүйн тогтолцоо тодорхой ач холбогдолтой байх талаар төрийн зүгээс их анхаардаг
- Хүснэгт 4.17 Монголын практик амьдралд “эрх зүйтэй” нягт холбоотой ойлголтуудыг сонгосон байдал
- Хүснэгт 4.18 Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтуудаас сонгосон байдал
- Хүснэгт 4.19 Нийгэм, улс төрийн идэвхийг үнэлсэн байдал
- Хүснэгт 4.20 УИХ-ын сонгууль
- Хүснэгт 4.21 УИХ-ын сонгуульд оролцсон иргэдийн санал өгсөн байдал
- Хүснэгт 4.22 Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон байдал
- Хүснэгт 4.23 Орон нутгийн сонгуульд оролцсон байдал
- Хүснэгт 5.1 Өөрчлөх, хүчингүй болгох хуулиуд
- Хүснэгт 5.2 Өөрчлөх, хүчингүй болгох хуулиуд
- Хүснэгт 5.3 Өөрчлөх шаардлагатай хууль, эрх зүйн салбар
- Хүснэгт 5.4 Гомдол гаргаж байсан захиргааны байгууллагууд
- Хүснэгт 5.5 Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтууд
- Хүснэгт 5.6 Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтууд

ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- График 1.1 1989-1990 онд Монголд өрнөсөн ардчилсан, тайван хувьсгалын дараа улс орны байдал бүхэлдээ хэрхэн өөрчлөгдсөн талаарх иргэдийн бодол
- График 1.2 Хуулиуд ерөнхийдөө ямар болсон талаарх иргэдийн санал
- График 1.3 Хуулиудад өөрчлөлт орсныг хэрхэн мэдэж авдаг вэ?
- График 1.4 Өдөр тутмын амьдралтай холбоотой хуулийн мэдлэгээ иргэд үнэлсэн байдал
- График 1.5 Албан газрууд урьд өмнөхөөсөө сайн ажиллаж байна уу? гэсэн асуултанд хариулсан байдал
- График 1.6 Шүүхэд очилгүй талуудыг хооронд нь эвлэрүүлэх, зөвлөгөө өгөх газруудын үүргийг хэр чухал гэж үздэг вэ? гэсэн асуултанд хариулсан байдал
- График 1.7 Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтууд
- График 1.8 Бусад хүмүүстэй ямагт шударга харьцах нь эцсийн эцэст өөрт нь эерэг үр дүн авчирдаг уу? гэсэн асуултанд хариулсан байдал
- График 2.1 1989-1990 онд Монголд өрнөсөн ардчилсан, тайван хувьсгалын дараа улс орны байдал бүхэлдээ хэрхэн өөрчлөгдсөн талаарх хуулийн салбарт ажиллагсдын бодол
- График 2.2 Хуулиуд ерөнхийдөө ямар болсон талаарх хуулийн салбарт ажиллагсдын санал
- График 2.3 Хуулиуд эсхүл эрх зүйн ямар нэг салбарыг сайжруулах шаардлагатай эсэх
- График 2.4 Монголын ард түмний амьдрал сайжрахад сайн хуулиуд нэмэр болох уу? гэсэн асуултанд хариулсан байдал
- График 2.5 Албан газрууд урьд өмнөхөөсөө сайн ажиллаж байна уу? гэсэн асуултанд хариулсан байдал
- График 2.6 Шүүхэд очилгүй талуудыг эвлэрүүлэх, зөвлөгөө өгөх газруудын үүргийн талаарх хуулийн салбарт ажиллагсдын санал
- График 2.7 Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтууд
- График 2.8 Бусад хүмүүстэй ямагт шударга харьцах нь эцсийн эцэст өөрт нь эерэг, сөрөг үр дүн авчирдаг гэж үздэг үү? гэсэн асуултанд хариулсан байдал

БҮЛЭГ I.

Судалгааны арга зүй, аргачлал

1. 1. Судалгааны зорилго

“Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийг хүлээн зөвшөөрч буй байдал” сэдэвт социологийн судалгаа нь 1990 оноос хойш хийгдэж буй Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийг жирийн ард иргэд болон хуулийн салбарт ажиллагсад хэрхэн хүлээн авч байгаа, хүмүүсийн хууль эрх зүйн талаарх санаа бодлыг илрүүлэх зэрэг үндсэн зорилгуудыг дэвшүүлснээс гадна мөн дараахь зорилгуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. 1989-1990 онд өрнөсөн ардчилсан тайван хувьсгалын дараахь Монгол Улсын байдлыг иргэд хэрхэн үнэлж байгаа.
2. Хуулийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулан таниулах ажлыг төрийн зүгээс хэр зэрэг чанартай явуулж байгаа.
3. Хууль, цагдаа, хүчний байгууллагуудын ажлын чанар, мэдлэгийг дам үнэлэх
4. Шүүх болон УИХ дахь өөрийн сонгосон төлөөлөгчдөө итгэдэг эсэх
5. Иргэдийн сонгуулийн идэвхи.
6. Өнгөрсөн УИХ-ын сонгуульд аль нам хүчнийг дэмжсэн болох.

1. 2. Судалгааны түүвэрлэлт

Судалгааны үндсэн нэгж нь Монгол Улсын хот, хөдөөгийн насанд хүрсэн жирийн иргэд болон хуулийн салбарт ажиллагсад байв. Судалгаанд санамсаргүй түүврийн аргыг хэрэглэсэн юм.

Судалгаанд Улаанбаатар хот, Баянхонгор, Ховд, Говь-Алтай, Дундговь, Төв, Завхан, Архангай, Өмнөговь, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ, Орхон, Хэнтий аймгуудын нийт 850 иргэн, Улаанбаатар хот болон Хөвсгөл, Ховд, Дорноговь, Дорнод, Архангай, Завхан, Өвөрхангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Хэнтий, Сэлэнгэ, Өмнөговь, Сүхбаатар, Дундговь, Төв, Увс, Говь-Алтай, Орхон, Баянхонгор, Булган, Говьсүмбэр аймгуудын хуулийн салбарын нийт 342 ажиллагсад хамрагдсан байна. Дээрх 850 иргэд болон хуулийн салбарт ажилладаг 342 хүн нь Монгол Улсын насанд хүрсэн иргэд болон нийт хуулийн салбарт ажиллагсдыг тодорхой хэмжээгээр төлөөлж чадах түүвэр юм. Америкийн судлаач Крежси, Морган нарын үзэж байгаагаар 5000 хүнтэй эх олонлогт түүврийн хэмжээ 357 хүн байхад алдааны дээд хязгаар 5 хувь, итгэлцүүрийн түвшин 95 хувь байх болно гэж үзсэн байдаг ба түүнчлэн Монголд үндэсний хэмжээний томоохон судалгаа явуулахад түүврийн хэмжээ 1000-1500 хүн байхад хангалттай гэдгийг олон судалгааны практик төдийгүй, туршлагатай судлаачид баталж байдаг.

Хэдийгээр түүврийн хэмжээ 850 иргэн, хуулийн салбарын 342 ажиллагсдаар тогтоогдсон нь хангалттай боловч төлөөлөх чадвар буюу бүтцийг оновчтой тогтоох нь юунаас илүү чухал байдаг. Судалгааныхаа түүврийн бүтцийг тогтоохдоо дараахь шалгууруудыг харгалзсан болно.

Үүнд:

- Судалгаанд оролцогчдын нас, хүйс
- Хуулийн салбарт ажилладаг эсэх
- Нийгмийн аль бүлэгт хамаарах
- Хот, аймгуудын төлөөлөл

Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийг хүлээн зөвшөөрч буй байдлыг нээн илрүүлэхэд судалгаанд оролцсон иргэдийн ерөнхий боловсролын түвшин туйлын чухал. Хүмүүсийн ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсролын түвшин өндөр байх тусам нийгэм дэх аливаа сөрөг болон эерэг үзэгдэл, үйл явцын талаар үнэн зөв дүгнэлт хийх чадвар нь нэмэгддэг. Энэ үүднээс судалгаанд хамрагдсан жирийн иргэдийн ерөнхий боловсролын түвшин, хуулийн салбарт ажиллагсдын ерөнхий болон дээд боловсролын түвшинг харгалзан үзсэн.

1.3. Судалгааны мэдээлэл цуглуулалт

Судалгааны мэдээллийг “Эрх зүйн боловсрол” академийн багийнхан 2005-2006 оны хооронд ихээхэн хүч заран ажиллаж, судалгааны мэдээллийг анкетын асуулгаар цуглуулсан. Анкет нь өргөн цар хүрээтэй олныг хамарсан мэдээллийг цуглуулахад тохиромжтой байдаг бөгөөд энэ аргаар цуглуулсан мэдээлэл нь судалж байгаа үзэгдлийн ерөнхий төлөв байдал, хандлага, зүй тогтлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Жирийн иргэд болон хуулийн салбарт ажиллагсдаас авах анкетын асуулгыг тус тусад нь “Эрх зүйн боловсрол” академи боловсруулсан. Жирийн иргэдээс авсан судалгааны анкетын асуулга нь дараахь хэсгүүдээс бүрдсэн:

1. Судалгаанд оролцогчийн тухай. Энд судалгаанд оролцогчийн хаана оршин суугаа, нас, хүйс, ерөнхий болон мэргэжлийн боловсрол, ажил эрхэлдэг байдлын тухай асуултууд багтсан.
2. Нийгмийн асуудал. Гэр бүлийн байдал, жилийн орлогын байдал, малын тоо, ам бүлийн тоо, радио, телевиз, интернет байгаа эсэх.
3. 1989-1990 онд өрнөсөн ардчилсан тайван хувьсгалын дараахь Монгол Улсын байдлыг хэрхэн үнэлж байгаа.
4. Одоо үйлчилж буй эрх зүйн тогтолцоо болон хуулиудын талаархи санаа бодол.
5. Хуулийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулан таниулах ажлыг төрийн зүгээс хэр зэрэг чанартай явуулж байгаа.
6. Хууль, цагдаа, хүчний байгууллагуудын ажлын чанар, мэдлэгийг дам үнэлэх.
7. Өдөр тутмын амьдралтай холбоотой хуулийн мэдлэгийн түвшин.
8. Шүүх болон УИХ дахь өөрийн сонгосон төлөөлөгчдөө итгэдэг эсэх.
9. Иргэдийн сонгуулийн идэвхи.
10. Өнгөрсөн УИХ-ын сонгуульд аль нам хүчнийг дэмжсэн гэх мэт асуултууд багтсан юм.

Хуулийн салбарын ажиллагсдаас авсан судалгааны анкетын асуулга нь дараахь хэсгүүдээс бүрдсэн:

1. Судалгаанд оролцогчийн тухай. Энд судалгаанд оролцогчийн хаана, оршин суугаа, нас, хүйс, ерөнхий болон мэргэжлийн боловсрол, ажил эрхэлдэг байдлын тухай асуултууд багтсан.
2. Нийгмийн асуудал. Гэр бүлийн байдал, жилийн орлогын байдал, малын тоо, ам бүлийн тоо, радио, телевиз, интернет байгаа эсэх.
3. Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийг хэрхэн хүлээн авч байгаа.
4. 1989-1990 онд өрнөсөн ардчилсан тайван хувьсгалын дараахь Монгол Улсын байдлыг хэрхэн үнэлж байгаа.
5. Одоо үйлчилж буй эрх зүйн тогтолцоо болон хуулиудын талаархи санаа бодол.
6. Хуулийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулан таниулах ажлыг төрийн зүгээс хэр зэрэг чанартай явуулж байгаа.
7. Хууль, цагдаа, хүчний байгууллагуудын ажлын чанар, мэдлэгийг дам үнэлэх.

8. Өдөр тутмын амьдралтай холбоотой хуулийн мэдлэгийн түвшин.
9. Шүүх болон УИХ дахь өөрийн сонгосон төлөөлөгчдөө итгэдэг эсэх.
10. Иргэдийн сонгуулийн идэвхи.
11. Өнгөрсөн УИХ-ын сонгуульд аль нам хүчнийг дэмжсэн гэх мэт асуултууд багтсан.

1. 4. Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээллийг боловсруулахад нийгмийн судалгааны мэдээлэл боловсруулах тусгай программ болох SPSS-11.0 программыг ашигласан.

БҮЛЭГ II.

“Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийг хүлээн зөвшөөрч буй байдал” социологийн судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл

Судалгаанд оролцсон иргэд хаана оршин сууж байгаа нь судалгаа Монгол орныг бүхэлд нь хамарч чадсан эсэхийг харуулна.

Хүснэгт 1.1. Хот, аймгуудаас судалгаанд хамрагдсан иргэдийн тоо, хувь

№	Хот, аймгийн нэр	Тоо	Хувь
1	Ховд	49	5.8
2	Баянхонгор	91	10.7
3	Говь-Алтай	17	2.0
4	Дундговь	17	2.0
5	Төв	18	2.1
6	Завхан	69	8.1
7	Увс	4	0.5
8	Архангай	75	8.8
9	Өмнөговь	23	2.7
10	Сүхбаатар	62	7.3
11	Улаанбаатар	308	36.2
12	Дорнод	1	0.1
13	Сэлэнгэ	3	0.4
14	Орхон	1	0.1
15	Хэнтий	1	0.1
16	Хариулаагүй	111	13.1
17	Бүгд	850	100%

Судалгаанд Монгол Улсын нийслэл, 21 аймгаас нийслэл Улаанбаатар хот, 14 аймаг хамрагдсан байна. Манай улсын хүн амын тал хувь нь оршин суудаг Улаанбаатар хотоос 36.2 хувь, хүн амынхаа тоогоор улсдаа тэргүүлдэг Ховд аймгаас 5.8 хувь, Завхан аймгаас 8.1 хувь, Төв 2.1 хувь, Архангай аймгаас 8.8 хувь оролцсон нь бүс нутгуудын жигд төлөөллийг хамруулж чадсаны илрэл юм. Хүснэгтээс үзэхэд зарим аймгуудаас цөөн төлөөлөл оролцсон мэт харагдаж байгаа. Энэ нь аль аймгаас оролцож байгаагаа хариулаагүй иргэдийн тоо 111, тэдний эзлэх хувь нь 13.1 байгаагаар тайлбарлагдана.

Судалгаанд оролцогчдын насыг дараахь байдлаар бүлэглэсэн болно.

Хүснэгт 1.2. Судалгаанд оролцогчдын нас

Насны бүлэг	Тоо	Хувь
20 хүртэл настай	262	30.8
21-30 настай	288	33.9
31-40 настай	113	13.3
41-50 настай	113	13.3
51-ээс дээш настай	38	4.5

Хариулаагүй	36	4.2
Бүгд	850	100%

Эндээс үзвэл судалгаанд оролцогчдын 64.7 хувийг 30 хүртэл насны залуус эзэлж байгаа бөгөөд энэ нь залуучуудын нийгмийн идэвхи сайн, судалгаанд оролцох сонирхол ихтэй байсныг илтгэж байна.

Судалгаанд оролцогчдыг хүйсийн хувьд авч үзвэл 44.7 хувь нь эрэгтэй, 52.0 хувь нь эмэгтэй, өөрийн хүйсийн талаар мэдээлэл өгөөгүй буюу хариулаагүй 3.3 хувь байна. Энэ нь уг судалгаа хүйсийн тэгш төлөөллийг ерөнхийд нь хамарч чадсаныг харуулж байна.

Хүснэгт 1.3. Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал

Гэр бүлийн байдал	Тоо	Хувь
Гэрлэсэн	243	28.6
Гэрлээгүй	366	43.1
Хариулаагүй	241	28.4
Бүгд	850	100%

Гэрлээгүй иргэдийн эзлэх хувь их байгаа нь судалгаанд оролцогчид насны хувьд залуу байсныг давхар баталж байна.

Хүснэгт 1.4. Судалгаанд оролцогчдын ерөнхий боловсролын түвшин

Ерөнхий боловсролын түвшин	Тоо	Хувь
Бүрэн бус дунд	43	5.1
Бүрэн дунд	667	78.5
Тусгай дунд	8	0.9
Бага	6	0.7
Хариулаагүй	126	18.8
Бүгд	850	100%

Хүснэгт 1.5. Ерөнхий боловсролын сургууль төгссөн он, бүлэглэсэн байдлаар

Ерөнхий боловсролын сургууль төгссөн он, бүлэглэсэн байдлаар	Тоо	Хувь
1970 он хүртэл	17	2.0
1971-1980 он хүртэл	47	5.5
1981-1990 он хүртэл	83	9.8
1991-2000 он хүртэл	168	19.8
2001 оноос хойш	307	36.1
Хариулаагүй	228	26.8
Бүгд	850	100%

Хүснэгт 1.6. Мэргэжлийн боловсрол, бүлэглэсэн байдлаар

Мэргэжлийн боловсрол, бүлэглэсэн байдлаар	Тоо	Хувь
Нийгмийн ухааны	13	1.5
Эдийн засгийн	26	3.1

Малчин	2	0.2
Мэргэжлийн ажилчин	2	0.2
Инженер	6	0.7
Хөдөө аж ахуйн	8	0.9
Хууль, эрх зүй, цэрэг, цагдаа	63	7.4
Хариулаагүй	730	85.9
Бүгд	850	100%

Энд мэргэжлийн боловсролыг бүлэглэхдээ судалгаанд оролцогчдын хариулсан байдлыг гол тулгуур болгон авч үзсэн юм. Нийгмийн ухааны мэргэжлийн боловсролд ихэвчлэн ерөнхий боловсролын сургуулийн багш нар болон нийгмийн ухааны бусад чиглэлийн мэргэжилтэй хүмүүсийг хамруулсан. Мэргэжлийн ажилчин гэсэн бүлэгт үсчин, оёдолчин, жолооч зэрэг мэргэжлийн хүмүүс багтсан болно.

Хүснэгт 1.7. Их, дээд сургуулийн чиглэл, бүлэглэсэн байдлаар

Их, дээд сургуулийн чиглэл, бүлэглэсэн байдлаар	Тоо	Хувь
Хөдөө аж ахуй	20	2.4
Нийгмийн ухаан	14	1.6
Эдийн засаг	26	3.1
Анагаах ухаан	4	0.5
Хэл шинжлэл	4	0.5
Инженер	8	0.9
Хууль, эрх зүй	79	9.3
Урлаг	1	0.1
Хариулаагүй	694	81.6
Бүгд	850	100%

Хүснэгт 6, 7-ийн үзүүлэлтүүд нь судалгаанд оролцсон иргэд энэ асуудалд ач холбогдол өгөөгүйг илэрхийлэх бөгөөд мэргэжлийн боловсрол, их дээд сургуулийн чиглэл гэсэн асуултууд зарим талаараа ижил ойлгогдсон байж болзошгүй. Тийм ч учраас судалгаанд оролцогчид аль нэгийг нь сонгох явдал анкетыг шивэх явцад нэлээд тохиолдож байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Хүснэгт 1.8. Судалгаанд оролцогчдын их, дээд сургууль төгссөн статус

Их, дээд сургууль төгссөн статус	Тоо	Хувь
Бакалавр	175	20.6
Диплом	56	6.6
Магистр	32	3.8
Хариулаагүй	587	69.1
Бүгд	850	100%

Хүснэгт 1.9. Судалгаанд оролцогчдын эрдмийн зэрэг, цол

Эрдмийн зэрэг, цол	Тоо	Хувь
Үгүй	12	1.4
Хариулаагүй	838	98.6
Бүгд	850	100%

Хүснэгт 1.10. Судалгаанд оролцогчдын мэргэжил

Мэргэжил	Тоо	Хувь
Нийгмийн ухааны	60	7.1
Эдийн засгийн	56	6.6
Малчин	3	0.4
Мэргэжлийн ажилчин	38	4.5
Инженер, техникийн	29	3.4
Анагаах, эрүүл мэндийн	6	0.7
Хууль эрх зүй, цагдаа, цэрэг	125	14.7
Хөдөө аж ахуйн	14	1.6
Урлагийн	1	0.1
Хэл шинжлэлийн	1	0.1
Хариулаагүй	517	60.8
Бүгд	850	100%

Судалгаанд оролцсон хүмүүсийн 60.8 хувь буюу 517 нь өөрийн мэргэжлийг бичээгүй нь тэдний наснаас шалтгаалж байгаа ба харин малчин гэсэн мэргэжлийн тухайд бол Монгол оронд 1990 оноос өмнө цөөн тооны хүмүүст малчин гэсэн мэргэжлийн үнэмлэх олгож байсантай холбоотой.

Хүснэгт 1.11. Судалгаанд оролцогчдын эрхэлдэг ажил

Эрхэлдэг ажил	Тоо	Хувь
Хувиараа чөлөөт мэргэжлээр ажил эрхэлдэг	88	10.4
Төрийн албан хаагч	235	27.6
Ажилчин	12	1.4
Гэрийн ажилтай	22	2.6
Тэтгэвэрт гарсан	12	1.4
Сурч байгаа	397	46.7
Малчин	28	3.3
Хариулаагүй	56	6.6
Бүгд	850	100%

Судалгаанд оролцогчдын хамгийн цөөн ам бүлтэй нь 1 байсан бөгөөд нийт 14 хүн ингэж хариулж 1.6 хувийг эзэлж байсан бол хамгийн олон ам бүлтэй нь 11 байсан бөгөөд ингэж хариулсан тохиолдол 1 удаа гарсан. Тиймээс судалгаанд оролцогчдын ам бүлийн тоог дараахь байдлаар бүлэглэв.

Хүснэгт 1.12. Ам бүлийн тоо, бүлэглэсэн байдлаар

Ам бүлийн тоо	Тоо	Хувь
2 хүртэл	39	4.6
3-5 ам бүлтэй	458	53.9
6 ба түүнээс дээш ам бүлтэй	169	19.9
Хариулаагүй	184	21.6
Бүгд	850	100%

Хүснэгт 1.13. Судалгаанд оролцогчдод радио байдаг эсэх

Танд радио байдаг уу?	Тоо	Хувь
Тийм	549	64.6
Үгүй	118	13.9
Хариулаагүй	183	21.5
Бүгд	850	100%

Хүснэгт 1.14. Судалгаанд оролцогчдод телевиз байдаг эсэх

Танд телевиз байдаг уу?	Тоо	Хувь
Тийм	700	82.4
Үгүй	18	2.1
Хариулаагүй	132	15.5
Бүгд	850	100%

Хүснэгт 1.15. Судалгаанд оролцогчдод интернет байдаг эсэх

Танд интернет байдаг уу?	Тоо	Хувь
Тийм	137	16.1
Үгүй	406	47.8
Хариулаагүй	307	36.1
Бүгд	850	100%

Судалгаанд оролцсон иргэдийн 260 нь буюу 30.6 хувь нь өрхийн жилийн орлогынхоо тухай бидэнд мэдээлээгүй байна. Огт орлогогүй гэж 9 хүн хариулсан нь 1.1 хувийг эзэлж байгаа бол жилд хамгийн өндөр орлоготой хүн 28 сая төгрөг гэж хариулжээ. Иймд иргэдийн өрхийн жилийн орлогыг дараахь байдлаар бүлэглэсэн болно.

Хүснэгт 1.16. Өрхийн жилийн орлого, бүлэглэсэн байдлаар

Өрхийн жилийн орлого	Тоо	Хувь
500000 хүртэл	71	8.4
500001-1000000	158	18.6
1000001-2000000	224	26.4
2000001-5000000	113	13.3
5000001-10000000	20	2.4
10000001-ээс дээш	4	0.5
Хариулаагүй	260	30.6
Бүгд	850	100%

Хүснэгт 1.17. Нийт малын тоо, бүлэглэсэн байдлаар

Малын тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой малтай	101	11.9
51-100 толгой малтай	31	3.6
101-300 толгой малтай	47	5.5
301-500 толгой малтай	13	1.5
501-1000 толгой малтай	12	1.4
1001-ээс дээш толгой малтай	1	0.1
Малгүй	31	3.6

Хариулаагүй	614	72.4
Бүгд	850	100%

Хүснэгт 1.18. Адууны тоо, бүлэглэсэн байдлаар

Адууны тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой	197	23.3
51-100 толгой	6	0.7
101-300 толгой	2	0.2
301-500 толгой	1	0.1
Хариулаагүй	642	75.5
Адуугүй	2	0.2
Бүгд	850	100%

Хүснэгт 1.19. Хонины тоо, бүлэглэсэн байдлаар

Хонины тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой	153	18.1
51-100 толгой	21	2.5
101-300 толгой	22	2.6
301-500 толгой	8	0.9
501-1000 толгой	2	0.2
1000-аас дээш толгой	2	0.2
Хариулаагүй	642	75.5
Бүгд	850	100%

Хүснэгт 1.20. Ямааны тоо, бүлэглэсэн байдлаар

Ямааны тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой	145	17.2
51-100 толгой	32	3.8
101-300 толгой	25	2.9
301-500 толгой	2	0.2
500-1001 толгой	2	0.2
1000-аас дээш толгой	2	0.2
Хариулаагүй	642	75.5
Бүгд	850	100%

Хүснэгт 1.21. Тэмээний тоо, бүлэглэсэн байдлаар

Тэмээний тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой	56	6.7
51-100 толгой	4	0.4
Хариулаагүй	642	75.5
Тэмээгүй	148	17.4
Бүгд	850	100%

Хүснэгт 1.22. Үхрийн тоо, бүлэглэсэн байдлаар

Үхрийн тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой	127	14.9
51-100 толгой	3	0.4
101-300 толгой	3	0.4
Хариулаагүй	642	75.5
Үхэргүй	75	8.8
Бүгд	850	100%

Ийнхүү судалгаанд оролцсон иргэдийн 642 нь буюу 75.5 нь малын тоог асуусан асуултанд хариулаагүй нь тэднийг малгүй гэсэн ангилалд хамруулах боломжтойг харуулж байна гэж үзэж болно.

БҮЛЭГ III.

“Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийг хүлээн зөвшөөрч буй байдал” социологийн судалгаанд оролцсон хуулийн салбарт ажиллагсдын мэдээлэл

Судалгаанд оролцсон иргэд хаана оршин сууж байгаа нь судалгаа Монгол орныг бүхэлд нь хамарч чадсан эсэхийг харуулна.

Хүснэгт 2.1. Хот, аймгуудаас судалгаанд хамрагдсан иргэдийн тоо, хувь

№	Хот, аймгийн нэр	Тоо	Хувь
1.	Хөвсгөл	24	7.0
2.	Ховд	8	2.3
3.	Дорноговь	4	1.2
4.	Дорнод	11	3.2
5.	Архангай	2	0.6
6.	Завхан	2	0.6
7.	Өвөрхангай	3	0.9
8.	Баян-Өлгий	2	0.6
9.	Дархан-Уул	5	1.5
10.	Хэнтий	3	0.9
11.	Сэлэнгэ	3	0.9
12.	Улаанбаатар	138	40.4
13.	Өмнөговь	1	0.3
14.	Сүхбаатар	4	1.2
15.	Дундговь	2	0.6
16.	Төв	2	0.6
17.	Увс	5	1.5
18.	Говь-Алтай	2	0.6
19.	Орхон	4	1.2
20.	Баянхонгор	2	0.6
21.	Булган	1	0.3
22.	Говьсүмбэр	1	0.3
23.	Хариулаагүй	113	33.0
24.	Бүгд	342	100%

Судалгаанд Монгол Улсын нийслэл, 21 аймгаас нийслэл Улаанбаатар хот, 21 аймаг хамрагдсан байна. Хууль, эрх зүйн үндсэн төв байрлаж, бодлого тодорхойлдог нийслэл Улаанбаатар хотоос 40.4 хувь, хүн амынхаа тоогоор улсдаа дээгүүр байранд ордог Хөвсгөл аймгаас 7.0 хувь оролцсон нь бүс нутгуудын жигд төлөөллийг хамруулж чадсаныг харуулж байна. Аль аймагт оршин суудаг хариулаагүй хүмүүсийн эзлэх хувь нь 33.0 хувь байгаа нь дээрх хүснэгтэнд зарим аймгуудаас цөөн төлөөлөл оролцсон мэт харагдаж байгаагийн тайлбар болно.

Судалгаанд оролцогчдын насыг дараахь байдлаар бүлэглэсэн болно.

Хүснэгт 2.2. Судалгаанд оролцогчдын нас

Насны бүлэг	Тоо	Хувь
20 хүртэл настай	10	2.9
21-30 настай	141	41.2
31-40 настай	84	24.6
41-50 настай	72	21.1
51-ээс дээш настай	27	7.9
Хариулаагүй	8	2.3
Бүгд	342	100%

Эндээс үзвэл судалгаанд оролцогчдын 65.8 хувийг 21-40 хүртэл насны хүмүүс эзэлж байгаа нь хуулийн салбарт ид идэвхитэй ажиллаж буй хэсгийг хамруулж чадсаныг харуулна. Энэ нь ч судалгааны үр дүн үнэн бодитой байхад эерэгээр нөлөөлөх нь гарцаагүй.

Судалгаанд оролцогчдыг хүйсийн хувьд авч үзвэл 44.7 хувь нь эрэгтэй, 53.8 хувь нь эмэгтэй, өөрийн хүйсийн талаар мэдээлэл өгөөгүй буюу хариулаагүй 1.5 хувь байна. Энэ нь судалгаа хүйсийн тэгш төлөөллийг хамарч чадсаныг илэрхийлж байна.

Хүснэгт 2.3. Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал

Гэр бүлийн байдал	Тоо	Хувь
Гэрлэсэн	237	69.3
Гэрлээгүй	95	27.8
Хариулаагүй	10	2.9
Бүгд	342	100%

Хүснэгт 2.4. Судалгаанд оролцогчдын ерөнхий боловсролын түвшин

Ерөнхий боловсролын түвшин	Тоо	Хувь
Бүрэн бус дунд	3	0.9
Бүрэн дунд	327	95.6
Бага	2	0.6
Хариулаагүй	1	0.3
Бүгд	342	100%

Ерөнхий боловсролын хувьд бүрэн дунд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 95.6 байгаа нь мэргэжлийн онцлог бөгөөд ихэнх тохиолдолд хуульчдыг заавал дээд боловсролын түвшинд бэлтгэж байсантай холбоотой. Ялангуяа сүүлийн 10 орчим жилд.

Хүснэгт 2.5. Ерөнхий боловсролын сургууль төгссөн он, бүлэглэсэн байдлаар

Ерөнхий боловсролын сургууль төгссөн он, бүлэглэсэн байдлаар	Тоо	Хувь
1970 он хүртэл	14	4.1
1971-1980 он хүртэл	59	17.3
1981-1990 он хүртэл	75	21.9
1991-2000 он хүртэл	130	38.0

2001 оноос хойш	9	2.6
Хариулаагүй	55	16.1
Бүгд	342	100%

Хүснэгт 2.6. Мэргэжлийн боловсрол, бүлэглэсэн байдлаар

Мэргэжлийн боловсрол, бүлэглэсэн байдлаар	Тоо	Хувь
Хууль	159	46.5
Багш	15	4.4
Инженер	53	15.5
Сэтгүүлч	52	15.2
Эдийн засаг	15	4.4
Эмч	17	5.0
Хөдөө аж ахуй	9	2.7
Нийгэм	4	1.2
Хариулаагүй	18	5.3
Бүгд	342	100%

Энд мэргэжлийн боловсролыг бүлэглэхдээ судалгаанд оролцогчдын хариулсан байдлыг гол тулгуур болгон авч үзсэн. Энд нэг зүйлийг дурьдахад судалгаанд хуулийн мэргэжлийн биш, хуулийн салбарт ажилладаг хүмүүсийг тусгайлан сонгосон юм.

Хүснэгт 2.7. Их, дээд сургуулийн чиглэл, бүлэглэсэн байдлаар

Их, дээд сургуулийн чиглэл, бүлэглэсэн байдлаар	Тоо	Хувь
Хууль	159	46.5
Багш	15	4.4
Инженер	53	15.5
Сэтгүүлч	52	15.2
Эдийн засаг	15	4.4
Эмч	17	5.0
Хөдөө аж ахуй	9	2.7
Нийгэм	4	1.2
Хариулаагүй	18	5.3
Бүгд	342	100%

Хүснэгт 6, 7-ийн үзүүлэлтүүд нь судалгаанд оролцогчдод мэргэжлийн боловсрол, их дээд сургуулийн чиглэл гэсэн асуудлууд ижил ойлгогдож байсныг харуулж байна.

Хүснэгт 2.8. Судалгаанд оролцогчдын их, дээд сургууль төгссөн статус

Их, дээд сургууль төгссөн статус	Тоо	Хувь
Бакалавр	222	64.9
Диплом	23	6.7
Магистр	62	18.1
Хариулаагүй	18	5.3
Бүгд	342	100%

Хүснэгт 2.9. Судалгаанд оролцогчдын эрдмийн зэрэг, цол

Эрдмийн зэрэг, цол	Тоо	Хувь
Доктор /Ph.D/	1	0.3
Хариулаагүй	341	99.7
Бүгд	342	100%

Хүснэгт 2.10. Судалгаанд оролцогчдын мэргэжил

Мэргэжил	Тоо	Хувь
Хуульч	150	43.9
Улс төр судлаач	2	0.6
Багш	15	4.4
Инженер	53	15.5
Сэтгүүлч	46	13.5
Эдийн засагч	13	3.8
Мөрдөн байцаагч	1	0.3
Хүний эмч	17	5.0
Архивч	2	0.6
Агрономич	3	0.9
Хүнсний технологич	4	1.2
Малын эмч	1	0.3
Социологич	1	0.3
Оюутан	16	4.7
Хариулаагүй	17	5.0
Бүгд	342	100%

Хүснэгт 2.11. Судалгаанд оролцогчдын эрхэлдэг ажил

Эрхэлдэг ажил	Тоо	Хувь
Хувиараа чөлөөт мэргэжлээр ажил эрхэлдэг	57	16.7
Төрийн албан хаагч	219	64.0
Ажилчин	1	0.3
Гэрийн ажилтай	2	0.6
Тэтгэвэрт гарсан	19	5.6
Сурч байгаа	5	1.5
Хариулаагүй	39	11.4
Бүгд	342	100%

Судалгаанд оролцогчдын хамгийн цөөн ам бүлтэй нь 1 байсан бөгөөд нийт 7 хүн ингэж хариулж 2.0 хувийг эзэлж байгаа бол хамгийн олон ам бүлтэй нь 10 байсан бөгөөд ингэж хариулсан тохиолдол 1 удаа гарч 0.3 хувийг эзэлж байв. Тиймээс судалгаанд оролцогчдын ам бүлийн тоог дараахь байдлаар бүлэглэсэн болно.

Хүснэгт 2.12. Ам бүлийн тоо, бүлэглэсэн байдлаар

Ам бүлийн тоо	Тоо	Хувь
2 хүртэл	29	8.5
3-5 ам бүлтэй	238	69.6
6 ба түүнээс дээш ам бүлтэй	36	10.5
Хариулаагүй	39	11.4
Бүгд	342	100%

Хүснэгт 2.13. Судалгаанд оролцогчдод радио байдаг эсэх

Танд радио байдаг уу?	Тоо	Хувь
Тийм	282	82.5
Үгүй	13	3.8
Хариулаагүй	47	13.7
Бүгд	342	100%

Хүснэгт 2.14. Судалгаанд оролцогчдод телевиз байдаг эсэх

Танд телевиз байдаг уу?	Тоо	Хувь
Тийм	299	87.4
Үгүй	5	1.5
Хариулаагүй	38	11.1
Бүгд	342	100%

Хүснэгт 2.15. Судалгаанд оролцогчдод интернет байдаг эсэх

Танд интернет байдаг уу?	Тоо	Хувь
Тийм	89	26.0
Үгүй	79	23.1
Хариулаагүй	174	50.9
Бүгд	342	100%

Судалгаанд оролцсон иргэдийн 88 нь буюу 25.7 хувь нь өрхийн жилийн орлогынхоо тухай бидэнд мэдээлээгүй байна. Хамгийн бага орлоготой нь 600.000 гэж хариулж 0.6 хувийг эзэлсэн бол хамгийн өндөр орлоготой нь 11 сая 520 мянган төгрөг гэж хариулжээ. Иймд судалгаанд оролцогчдын өрхийн жилийн орлогыг дараахь байдлаар бүлэглэн үзүүлэв.

Хүснэгт 2.16. Өрхийн жилийн орлого, бүлэглэсэн байдлаар

Өрхийн жилийн орлого	Тоо	Хувь
500000 хүртэл	18	5.3
500001-1000000	52	15.2
1000001-2000000	134	39.2
2000001-5000000	43	12.6
5000001-10000000	5	1.5
10000001-ээс дээш	2	0.6
Хариулаагүй	88	25.7
Бүгд	342	100%

Хүснэгт 2.17. Нийт малын тоо, бүлэглэсэн байдлаар

Малын тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой малтай	11	3.2
51-100 толгой малтай	11	3.2
101-300 толгой малтай	8	2.3
301-500 толгой малтай	2	0.6
Малгүй	97	28.4

Хариулаагүй	213	62.3
Бүгд	342	100%

Хүснэгт 2.18. Адууны тоо, бүлэглэсэн байдлаар

Адууны тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой	22	6.4
51-100 толгой	1	0.3
101-300 толгой	1	0.3
Хариулаагүй	216	63.2
Алгассан буюу адуугүй	102	29.8
Бүгд	342	100%

Хүснэгт 2.19. Хонины тоо, бүлэглэсэн байдлаар

Хонины тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой	128	37.4
Хариулаагүй	214	62.9
Бүгд	342	100%

Хүснэгт 2.20. Ямааны тоо, бүлэглэсэн байдлаар

Ямааны тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой	22	6.4
51-100 толгой	3	0.9
101-300 толгой	2	0.6
Хариулаагүй	214	75.5
Алгассан буюу ямаагүй	101	29.5
Бүгд	850	100%

Хүснэгт 2.21. Тэмээний тоо, бүлэглэсэн байдлаар

Тэмээний тоо	Тоо	Хувь
5 тэмээтэй	1	0.3
Алгассан буюу тэмээгүй	124	36.3
Хариулаагүй	217	63.5
Бүгд	342	100%

Хүснэгт 2.22. Үхрийн тоо, бүлэглэсэн байдлаар

Үхрийн тоо	Тоо	Хувь
50 хүртэл толгой	25	7.3
54 үхэртэй	1	0.3
Хариулаагүй	214	62.6
Алгассан буюу үхэргүй	102	29.8
Бүгд	342	100%

Судалгаанд оролцсон иргэдийн 213 нь буюу 62.3 нь малын тоог асуусан асуултанд хариулаагүй нь тэднийг малгүй гэсэн ангилалд хамруулах боломжтойг харуулж байна.


БҮЛЭГ IV.

“Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийг хүлээн зөвшөөрч буй байдал” социологийн судалгааны тайлан

(жирийн иргэдээс авсан судалгаа)

1. 1989-1990 онд Монголд өрнөсөн ардчилсан, тайван хувьсгалын дараа улс орны байдал бүхэлдээ хэрхэн өөрчлөгдсөн талаарх судалгаанд оролцогчдын санаа бодлыг дараахь графикаар үзүүлэв.


График 1.1



Дээрх үр дүнгээс үзэхэд иргэдийн 58 орчим хувь нь ардчилсан хувьсгал ялснаас хойш Монгол орны байдал бүхэлдээ сайжирсан гэж хариулж байгаа нь иргэдийн ирээдүйдээ итгэх итгэл, тухайн жилүүдэд оршин байсан засгийн газруудын үйл ажиллагааг дэмжиж байсны илрэл болж байна.

2. Хуулиуд ерөнхийдөө ямар болсон гэж үздэг вэ? гэсэн асуултанд хариулсан байдлыг дараахь графикт үзүүлэв.

График 1.2



Эндээс үзвэл судалгаанд оролцогчдын 47.8 хувь нь 1990 оноос хойш батлагдсан, шинэчлэгдсэн хуулиудыг сайн, өмнөхөөсөө сайжирсан хэмээн дүгнэж бусад сонголтуудаас харьцангуй давуу байгаа ч **ойролцоогоор хуучин хэвээр үлдсэн, муудсан, мэдэхгүй** гэсэн хариултын нийлбэр нь 49.4 хувь болж байна. Хэдийгээр сайжирсан гэсэн үнэлгээ давуу байгаа ч иргэдийн зүгээс шинэчлэгдсэн хуулиудыг хангалттай хүлээн авахгүй байгааг харуулж байна.

3. Төр, хууль тогтоогчийн зүгээс хуулийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулах тал дээр хичээж ажилладаг уу? гэсэн асуутанд **тийм, их зүтгэл гаргадаг** гэж 14.4 хувь нь, **бага зэрэг хичээл зүтгэл гаргадаг** гэж 48.9 хувь нь, **иргэн хүн хуулийн утга агуулгыг ойлгох эсэх нь төрд хамаагүй** гэж 17.5 хувь нь, **энэ асуудал төрд огт хамаагүй** гэж 2.4 хувь нь, **мэдэхгүй** гэж 14.9 хувь нь тус тус хариулсан байна. Энэ асуултанд нийт оролцогчдын 1.9 хувь хариулаагүй алгассан байна. Судалгааны үр дүнгээс үзвэл төрөөс хууль, тогтоомжийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулах ажил хангалтгүй явагдаж байгаа нь харагдаж байна.


4. Монголд хэт олон хууль байна уу? Хэт олон зүйлийг хуулиар зохицуулдаг уу? Хууль хэтэрхий цөөн байна уу? Хэт цөөн зүйлийг хуулиар зохицуулж байна уу? Эсхүл яг тохирсон гэж үздэг үү? гэсэн асуултанд 31.9 хувь нь **хэт олон хууль байдаг, хэт олон зүйлийг хуулиар зохицуулсан**, 14.2 хувь нь **хууль яг тохирсон**, 19.1 хувь нь **хэт цөөн хууль байдаг, хэт цөөн зүйлийг хуулиар зохицуулсан**, 32.0 хувь нь **мэдэхгүй** хэмээн тус тус хариулж, 2.8 хувь нь асуултыг алгассан байна. Энэ асуулт нь тухайн хариулагч хүний хуулийн мэдлэг, эрхэлдэг ажил гээд олон зүйлээс шалтгаалан хариу нь өөр өөр байх нь ойлгомжтой. Гэхдээ иргэдийн олонхи нь энэ талаар мэдлэг бага байгаа учраас мэдэхгүй гэсэн хариултыг сонгосон бол 31.9 хувь нь өнөөгийн нийгэмд үйлчилж буй хуулиудыг хэт олон байна, хэт олон зүйлийг хуульчилсан гэж үзжээ.

5. Эрх зүйн болон хуулийн зохицуулалт ямар ч шаардлагагүй, ярвигтай байдаг гэж зарим хүн үздэг. Нөгөө хэсэг нь манай нийгэм болон хуулиар зохицуулагдах хүчин зүйлс нь ярвигтай учраас хуулиуд мөн ярвигтай байх ёстой гэж үздэг. Та ямар бодолтой байдаг вэ? гэсэн асуултанд **хуулиуд өөрөө ярвигтай учраас нийгэм, амьдралыг ярвигтай болгодог** гэж 29.9 хувь нь, **нийгмийн амьдралыг зохицуулах нь хэдийгээр хэцүү боловч хуулиуд бага зэрэг ч гэсэн хялбархан байж болмоор** гэж 35.1 хувь нь, **манай нийгэм өөрөө ярвигтай учраас хуулиуд ч гэсэн ярвигтай** гэж 9.5 хувь нь, **үүнийг дүгнэж хэлж мэдэхгүй** гэж 20.5 хувь нь тус тус хариулж 5.1 хувь нь хариулаагүй байна. Эндээс үзэхэд хуулиуд ярвигтай учраас нийгмийг ярвигтай болгодог, нийгмийг зохицуулах нь хэцүү боловч хууль хялбар байж болмоор гэсэн ойролцоо утгатай хариултуудыг нийт оролцогчдын 65 хувь нь сонгосон нь үйлчилж буй хуулиуд нь иргэдэд ойлгогдохгүй ярвигтай байгаа нь харагдаж байна.

6. Хуулийг ямар ч нөхцөлд, хүн бүхэнд адил чанга хэрэглэх ёстой юу? Эсхүл тодорхой тохиолдолд (тухайлбал, санамсар болгоомжгүйгээр гэмт хэрэгт холбогдох, өвчин г. м) хөнгөрүүлэн хэрэглэх ёстой юу? гэсэн асуултын **хуулийг ямагт адил хэмжээгээр чанга хэрэглэх ёстой** гэсэн хариултыг 36.0 хувь нь, **онцгой тохиолдолд шүүгч хуулиар олгогдсон хөнгөрүүлэх нөхцөл байдлаас өөр хөнгөн хуулийг хэрэглэх боломжтой байх ёстой** гэсэн хариултыг 52.6 хувь нь, **мэдэхгүй** гэсэн сонголтыг 7.2 хувь нь тус тус хийж 4.2 нь хариулаагүй. Үүнээс үзэхэд санамсар болгоомжгүйгээр гэмт хэрэгт холбогдсон, өвчний улмаас ял эдлэх боломжгүй нөхцөлд шүүгчийг хөнгөн хууль хэрэглэхийг иргэд дэмжиж байгаа нь харагдаж байна.

7. Та хуулиудад өөрчлөлт орсныг хэрхэн мэдэж авдаг вэ? гэсэн асуултанд хариулсан байдлыг дараахь графикаар үзүүлэв.

График 1.3



8. Таны нүдэнд туссан эрх зүйн дутагдалтай байдал болон шударга бус байдлыг юунаас үүдэлтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултыг өгөөд дараахь найман сонголтыг өгчээ. Ингээд иргэд найман хүчин зүйлийн алинаас нь шударга бус байдал үүдэлтэй гэж үзсэнийг хүснэгтээр үзье.

Хүснэгт 3.1. Эрх зүйн дутагдалтай байдал, шударга бус байдлыг юунаас үүдэлтэйг хариулсан байдал

Өгөгдсөн хариултууд	Давхардсан тоо	Хувь	Давхардсан хувь
Хуулиуд алдаатай учраас	291	18.2	35.1
Шүүгчид муу ажилладаг учраас	261	16.3	31.4
Цагдаагийн байгууллага муу ажилладаг учраас	309	19.3	37.2
Төрийн албан хаагчид муу ажилладаг учраас	239	15.0	28.8
Одоогоор хангалттай сайн болоогүй байна, гэхдээ өмнө үүнээс ч дор байсан, цаашид сайжрах байх гэж бодож байна.	281	17.6	33.9
Урьд өмнө нь үүнээс илүү сайн байсан, улам муудах байх гэж бодож байна.	58	3.6	7.0
Тийм ч муу гэж бодохгүй байна.	100	6.3	12.0
Мэдэхгүй	58	3.6	7.0
Бүгд	1597	100%	192.4

9. Та санал нийлэхгүй байгаагийн улмаас өөрчлөх эсхүл бүр байхгүй болгох хуулийн тодорхой заалт байдаг уу? гэсэн асуултанд иргэдийн хариулсныг дараахь хүснэгтээр үзүүлье.

Хүснэгт 3.2. Өөрчлөх, хүчингүй болгох хуулийн жагсаалт


Хариултууд	Тоо	Хувь
Мэдэхгүй	437	51.4
Боловсролын тухай хууль	8	0.9
Банкны тухай хууль	3	0.4
Нийгмийн даатгалын тухай хууль	1	0.1
Газар өмчлөлийн хууль	10	1.2
Эрүүгийн хууль	22	2.6
Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	2	0.2
Сонгуулийн тухай хууль	2	0.2
Ойн тухай хууль	1	0.1
Үндсэн хууль	1	0.1
Хөдөлмөрийн тухай хууль	1	0.1
Улс төрийн намуудын тухай хууль	1	0.1
Ашигт малтмалын тухай хууль	9	1.1
Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль	2	0.2
Иргэний хууль	2	0.2
Авилгалын тухай хууль	1	0.1
Эрүүл мэндийн тухай хууль	1	0.1
Хариулаагүй	346	40.7
Бүгд	850	100%

Эндээс үзэхэд иргэдийн хуулийн тухай мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа нь харагдаж байгаа бөгөөд цөөн хэдэн хүн өөрийн мэргэжилтэй холбогдох хуулиудыг нэрлэсэн байна. Гэхдээ дээрх нэр дурьдагдсан хуулиудаар тухайн хууль үйлчилдэг, хэрэглэгддэг мэргэжлийн хүмүүс болон нийт иргэдийн дунд хуулийн зүйл, заалтыг тодорхой дурьдсан сонголт бүхий асуулгыг дахин явуулах хэрэгтэйг харуулж байна.

10. Эрх зүйн асуудалтай тулгарвал та өөрийгөө яаж дүгнэх вэ? гэсэн асуултанд судалгаанд хамрагдагсдын 16.9 хувь нь **өөртөө туслах чадвартай** гэж итгэлтэй хариулсан бол 57.1 хувь нь **зарим үед өөрөө өөртөө туслах чадвартай, гэхдээ бусдын зөвлөгөө, тусламж хэрэгтэй** гэж хариулжээ. Харин 15.5 хувь нь **өөрөө өөртөө тусалж бараг чадахгүй байх, ерөнхийдөө бусдын гар харна** гэсэн бол 2.5 хувь нь **нэг мөсөн хүний гарт орсон мэт байна**, 4.2 хувь нь **мэдэхгүй** гэж хариулсан бөгөөд 3.8 хувь нь уг асуултанд хариулаагүй байна. Энэ нь иргэд эрх зүйн асуудалтай тулгарвал өөртөө хэрэгтэй зохих хуулийн мэдлэггүй байгааг шууд харуулж байна.

11. Бидний өдөр тутмын амьдралтай холбоотой хуулиудын талаархи мэдлэгээ та хэрхэн дүгнэх вэ? гэсэн асуултанд хариулсан байдлыг дараахь графикаар үзүүлье.

График 1.4



Хүмүүс ерөнхийдөө мэднэ, бага мэднэ гэсэн итгэлгүй, гуйвсан хариултыг ихэвчлэн сонгосноос гадна ойролцоогоор судалгаанд оролцсон 10 хүн тутмын 1 нь өдөр тутмын амьдралд холбогдох хуулийн талаар огт мэдлэггүйгээ шууд илэрхийлсэн байна. Энэ нь хуулийн мэдлэг дутмаг байгааг тодорхой харуулж байна.

Хүснэгт 3.3. Монголын ард түмний амьдрал сайжрахад сайн хуулиуд нэмэр болох уу?

Хариулт	Тоо	Хувь
Нэмэр болно	678	79.8
Үгүй, нэмэр болохгүй	55	6.5
Мэдэхгүй	78	9.2
Хариулаагүй	39	4.6
Бүгд	850	100%

Эндээс үзвэл иргэдийн хуульд итгэх итгэл алдраагүй байгаа бөгөөд сайн хуулиуд шаардлагатай байгааг харж болно.

Хүснэгт 3.4. Танд эрх зүйн болон хуулийн зөвлөгөө хэрэгтэй юу?

Хариулт	Тоо	Хувь
Үгүй, хэрэггүй	140	16.5
Мэдэхгүй	342	40.2
Хэрэгтэй	176	20.7
Хариулаагүй	192	22.6
Бүгд	850	100%

Анкетын асуулгын сонголтонд хэрэгтэй гэсэн хувилбар байгаагүй боловч асуулгыг шивэх явцад хэрэгтэй гэж гараар бичсэн тохиолдол их таарсан тул сонголт болгож оруулсан болно. Үүнээс үзэхэд хэрэгтэй гэсэн сонголтыг оруулсан бол мэдэхгүй болон хариулаагүй хүмүүсийн дийлэнх хувь нь сонгох байсан болов уу гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Тиймээс хүмүүсийн дунд хууль, эрх зүйн зөвлөгөө хэрэгтэй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 3.5. Захиргааны байгууллагын шийдвэрт та гомдол гаргаж байсан уу?

Хариулт	Тоо	Хувь
Тийм	59	6.9
Үгүй	701	82.5
Мэдэхгүй	34	4.0
Хариулаагүй	56	6.6
Бүгд	850	100%

Дээрхи асуултанд гомдол гаргаж байсан гэж хариулсан иргэдийн ямар байгууллагад гаргасныг дараахь хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 3.6. Гомдол гаргаж байсан байгууллагуудын нэр


Байгууллагын нэр	Тоо	Судалгаанд оролцсон 850 иргэдтэй харьцуулсан хувь
Цагдаагийн газарт	9	1.1
Шүүхэд	11	1.3
Прокурорт	2	0.2
Замын цагдаагийн газарт	2	0.2
Мэргэжлийн хяналтын газарт	1	0.1
Хариулаагүй	34	4.0
Бүгд	59	6.9

Судалгааны анкетын асуулгыг шивэх үед иргэдийн зарим нь дээрхи асуултанд хариулаагүй эсхүл мэдэхгүй гэсэн хариултыг сонгосон боловч гомдол гаргаад амжилт олсон эсэх асуултанд хариулсан. Иймээс дүнг дараахь хүснэгтэнд судалгааны түүвэрт орсон 850 иргэнтэйгээ хувилан харуулав.

Хүснэгт 3.7. Гомдол гаргасан иргэдийн амжилт олсон байдал

Хариулт	Тоо	Хувь
Амжилт олсон	33	3.9
Амжилт олоогүйгээр үл барам энэ нь надад муугаар нөлөөлсөн	50	5.9
Амжилт олоогүй	16	1.9
Мэдэхгүй	209	24.6
Хариулаагүй	542	63.7
Бүгд	850	100%

График 1.5



Дээрхи графикаас үзвэл албан газрууд урд өмнөхөөсөө муу ажиллаж байгаа нь илт байна.

- Та өөрт холбогдох ямар нэг асуудлыг шүүхээр шийдвэрлүүлж байсан уу?


Хүснэгт 3.8. Шүүхээр асуудал шийдүүлж байсан байдал

Хариулт	Тоо	Хувь
Тийм	145	17.1
Үгүй	629	74.0
Хариулаагүй	76	8.9
Бүгд	850	100%

12. Та өөрийнхөө зөв гэдэгт бүрэн итгэлтэй байгаад шүүх үүнийг баталгаажуулна гэдэгт эргэлздэг үү? гэсэн асуултанд **үүнд санаа зовдоггүй, би хуулийн байгууллага, шүүгч нарт бүрэн итгэдэг** гэж 22.0 хувь нь, **шүүх зуун хувь шударга шийдвэр гаргана гэдэгт бага зэрэг эргэлздэг** гэж 32.5 хувь нь, тухайн **шүүгч болон прокуророос их зүйл хамаардаг учраас нэлээд их эргэлздэг** гэж 29.4 хувь нь, **мэдэхгүй** гэж 10.5 хувь нь хариулсан бөгөөд уг асуултанд хариулалгүйгээр 5.6 хувь нь алгассан байна. Эндээс үзвэл нийт ард олны дунд шүүхэд итгэх итгэл сул байгаа нь харагдаж байна.

13. Шүүхэд очилгүй талуудыг хооронд нь эвлэрүүлэх, зөвлөгөө өгөх газруудын үүргийг хэр чухал гэж үздэг вэ? гэсэн асуултанд хариулсан байдлыг графикаар үзүүлье.

График 1.6



Эндээс үзэхэд иргэдэд шүүхэд очилгүй талуудыг эвлэрүүлэх, зөвлөгөө өгөх газруудын шаардлага, хэрэгцээ байгаа нь харагдаж байна. Гэхдээ энэ талаар жирийн иргэдийн мэдлэг, ойлголт хомс байгааг мэдэхгүй гэсэн хариулт 19.3 хувийг эзэлж буйгаар тайлбарлаж болно. Манай улсад ч ийм чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд ховор байдаг. Тэгэхээр шүүхэд очилгүй талуудыг хооронд нь эвлэрүүлдэг, зөвлөгөө өгдөг байгууллагуудын тоог нь нэмэгдүүлэхэд төрийн болон олон нийтийн байгууллагуудын зүгээс анхаарах нь зүйтэй болов уу.

14. Шүүхийн шийдвэр гаргаж буй практикаас харахад манай хуулиуд бүхий л зөрчилдөөнийг урьдчилан харж зохицуулалт хийгээгүй байдаг. Иймээс шийдвэр гаргахад нь шүүгчид тодорхой эрх чөлөө олгосон байдаг. Та ямар бодолтой байна вэ? гэсэн асуултанд **шүүх болон шүүгч нар энэ эрх чөлөөгөө шударга ёсны төлөө ашигладаг гэдэгт итгэдэг** гэж 26.9 хувь нь, **гарч болохуйц бүхий л зөрчилдөөнийг хууль тогтоогч зохицуулж өгөх ёстой. Ингэснээрээ шүүгчдийн шийдвэр гаргах эрх чөлөөг багасгах юм** гэж 41.3 хувь нь, **мэдэхгүй** гэж 24.1 хувь нь хариулсан бол 7.6 хувь нь энэ асуултыг алгассан байна. Эндээс иргэд шүүгчдийн эрх чөлөөг багасгах сонирхолтой байгаа нь харагдах бөгөөд үүний цаана шүүгчид итгэх итгэл сул байгаа нь мэдрэгдэж байна.

15. Бидэнд эрх зүй, хуулийн зохицуулалт заавал хэрэгтэй юу? Эсхүл хүмүүс хоорондоо зохицоод байж болох уу, өөрөөр хэлбэл “шүүгчийн хэрэг байхгүй” гэж үзэж байна уу? гэсэн асуултанд иргэдийн 82.4 хувь нь **бидэнд эрх зүй, хууль заавал хэрэгтэй** гэсэн хариуг сонгосон бол 5.5 хувь нь **эрх зүй, хуульгүйгээр хүмүүс хоорондоо зохицоод явах нь магадгүй дээр** гэсэн хариуг сонгож, 24.1 хувь нь **мэдэхгүй** гэсэн бол 7.6 хувь нь хариулаагүй. Асуулгын дүнгээс үзвэл иргэдэд хууль заавал хэрэгтэй нь илт байна.

16. Монгол Улсын Үндсэн хуульд ард түмэн ардчилсан сонгуулиар сонгогдсон УИХ-аар дамжуулан төрийн эрхийг барина хэмээн заасан байдаг Та дараахь өгүүлбэрүүдийг хэрхэн үзэж байна вэ? гэсэн асуултын үр дүнгүүдийг хүснэгтүүдээр үзүүлье.

Хүснэгт 3.9. Би УИХ дахь өөрийн сонгосон төлөөлөгчдөө сэтгэл хангалуун байдаг.

Хариулт	Тоо	Хувь
Үнэн	249	29.3
Худлаа	392	46.1

Мэдэхгүй	145	17.1
Хариулаагүй	64	7.5
Бүгд	850	100%

Хүснэгт 3.10. УИХ-аас иргэдийн сэтгэлд нийцдэггүй хууль батлан гаргадаг.

Хариулт	Тоо	Хувь
Үнэн	377	44.4
Худлаа	129	15.2
Мэдэхгүй	263	30.9
Хариулаагүй	81	9.5
Бүгд	850	100%

Хүснэгт 3.11. УИХ буюу УИХ-ын гишүүд бидэнд үүрэг ногдуулахаас бус бидний эрхийн талаар санаа тавьдаггүй.

Хариулт	Тоо	Хувь
Үнэн	462	54.4
Худлаа	128	15.1
Мэдэхгүй	197	23.2
Хариулаагүй	63	7.4
Бүгд	850	100%

Хүснэгт 3.12. УИХ-ын гишүүд жирийн иргэдийн бодол санаа, хүсэл зоригт их анхаарал тавьдаг.

Хариулт	Тоо	Хувь
Үнэн	91	10.7
Худлаа	552	64.9
Мэдэхгүй	181	21.3
Хариулаагүй	26	3.1
Бүгд	850	100%

Хүснэгт 3.13. Хууль хэрхэн батлагдан гарсныг жирийн иргэд ойлгодоггүй.

Хариулт	Тоо	Хувь
Үнэн	548	64.5
Худлаа	94	11.1
Мэдэхгүй	166	19.5
Хариулаагүй	42	4.9
Бүгд	850	100%

Хүснэгт 3.14. Эрх зүйн тогтолцоо тодорхой ач холбогдолтой байх талаар төрийн зүгээс их анхаардаг.


Хариулт	Тоо	Хувь
Үнэн	217	25.5
Худлаа	270	31.8
Мэдэхгүй	313	36.8
Хариулаагүй	50	5.9

Бүгд	850	100%
------	-----	------

Эдгээр үр дүнгүүдээс үзэхэд иргэд өөрийн төлөөлөл болгон сонгосон УИХ-ын гишүүддээ итгэл алдарсан нь харагдаж байна. Мөн УИХ-ын гишүүд өөрийг нь сонгосон тойргийн иргэдтэй ажилладаггүй, сонгогдоод алга болдог нь тодорхой бөгөөд төрийн зүгээс баримтлах ёстой эрх зүйн тодорхой бодлогын талаар ард иргэд ойлголтгүй байгаа нь харагдаж байна.

17. Ямар ойлголтуудыг “эрх зүй”-тэй холбон ойлгох ёстой гэж та үзэж байна вэ? гэсэн асуултын хариултыг дараахь графикаар үзүүлэв.

График 1.7




Мөн 14 сонголтын давхардсан тоо, хувь, давхардсан хувийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3.15. Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтууд

Өгөгдсөн сонголтууд	Давхардсан тоо	Хувь	Давхардсан хувь
Шударга ёс	567	24.9	71.2
Олон нийтийн аюулгүй байдал	194	8.5	24.4
Эрх чөлөө	327	14.3	41.1
Хэв журам	227	10.0	28.5
Захиргааны албан газрууд	79	3.5	9.9
Шүүх	148	6.5	18.6
Цагдаа	79	3.5	9.9
Эрх зүйн аюулгүй байдал	200	8.8	25.1
Адил тэгш байх зарчим	302	13.2	37.9
Зөрчлийг шийдэх	81	3.6	10.2
Бусдын гарт орсон мэт байх	20	0.9	2.5
Албадлага	22	1.0	2.8

Ухаан мэдрэл алдсан мэт байдал	12	0.5	1.5
Мэдэхгүй	22	1.0	2.8
Бүгд	2280	100%	286.4%

График 1. 8



Эндээс үзэхэд өнөөгийн Монголын нийгмийн дийлэнх хувь нь шударга ёсыг эрхэмлэн дээдэлдэг боловч амьдрал дээр шударга байх зарчмыг тэр болгон баримтлаад байдаггүй гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

18. Захиргааны байгууллага, албан хаагчийн шийдвэрийг хууль бус гэж үзвэл шүүхэд хандах боломж иргэдэд олгогдсон. Та үүнийг юу гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд **энэ нь надад эергээр нөлөөлнө** гэж 38.7 хувь нь, **захиргааны албан хаагч эсхүл захиргааны байгууллагын шийдвэрт гомдол гаргах нь эцэстээ надад сөрөг үр дагавар авчирна** гэж 18.8 хувь нь, **надад ямар ч нөлөө байхгүй** гэж 14.6 хувь нь, **мэдэхгүй** гэж 21.8 хувь нь хариулсан бөгөөд 6.1 хувь нь энэ асуултанд хариулаагүй байна. Энэ үр дүн нь Монголд шинээр байгуулагдсан захиргааны хэргийн шүүхийн талаархи ард олны ойлголтыг харуулж байгаа бөгөөд хүмүүс тодорхой ойлголттой болсон нь харагдаж байна.

19. Та өөрийнхөө нийгмийн идэвхийг хэрхэн дүгнэх вэ? гэсэн асуулт байсан бөгөөд сонгох хариулт тав байсан.

Хүснэгт 3.16. Нийгэм, улс төрийн идэвхийг дүгнэсэн байдал

Өгөгдсөн сонголтууд	Давхардсан тоо	Хувь	Давхардсан хувь
Сонгуульд тогтмол оролцдог, сонгуулийг өнгөрөөхгүйг боддог	439	29.9	55.7
Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцдог	230	15.7	29.2
Улс төрд их сонирхолтой	232	15.8	29.4
Найз нөхөд танилуудтайгаа улс төрийн тухай их ярилцдаг	289	19.7	36.7
Зөв гэсэн итгэл үнэмшилтэй бол улс	278	18.9	35.3

төрийн жагсаал цуглаанд оролцоно			
Бүгд	1468	100	186.3

20. Сүүлийн сонгуулиудад оролцсон байдал: Та хамгийн сүүлийн сонгуульд оролцсон уу? гэсэн асуулгын үр дүнг дараахь хүснэгтүүдэд үзүүлье.

Хүснэгт 3.17. УИХ-ын сонгууль

Хариулт	Тоо	Хувь
Тийм	659	77.5
Үгүй	126	14.8
Хариулт байхгүй	17	2.0
Хариулаагүй	48	5.6
Бүгд	850	100%

Хүснэгт 3.18. УИХ-ын сонгуульд оролцсон иргэдийн санал өгсөн байдал

Нам, эвсэлийн нэр	Тоо	Хувь
Хоосон орхисон	143	16.8
МАХН	333	39.2
“Эх орон-Ардчилал” эвсэл	191	22.5
Бусад нам	54	6.4
Хариулаагүй	129	15.2
Бүгд	850	100%

Хүснэгт 3.19. Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон байдал

Хариулт	Тоо	Хувь
Тийм	548	64.5
Үгүй	199	23.4
Хариулаагүй	103	12.1
Бүгд	850	100%

Хүснэгт 3.20. Орон нутгийн сонгуульд оролцсон байдал

Хариулт	Тоо	Хувь
Тийм	471	55.4
Үгүй	246	28.9
Хариулт байхгүй	21	2.5
Хариулаагүй	112	13.2
Бүгд	850	100%

Эндээс үзэхэд сүүлд болсон УИХ, Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын идэвхи өндөр байсан ба харин орон нутгийн сонгуульд иргэдийн идэвхи сул байсан нь харагдаж байна.


БҮЛЭГ V.

“Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийг хүлээн зөвшөөрч буй байдал” социологийн судалгааны тайлан

(Хуулийн салбарт ажиллагсдаас авсан судалгаа)

1. 1989-1990 онд Монгол оронд өрнөсөн ардчилсан тайван хувьсгалын дараа Монгол Улсын байдал бүхэлдээ хэрхэн өөрчлөгдсөн талаарх судалгаанд оролцогчдын санаа бодлыг дараахь графикаар үзүүлэв.

График 2.1



Эндээс үзэхэд хуулийн салбарт ажиллагсдын 80 орчим хувь нь Цагаан морин жилийн ардчилсан хувьсгал ялснаас хойш Монгол орны байдал бүхэлдээ сайжирсан гэж хариулж байгаа нь ирээдүйдээ итгэх итгэл, тухайн жилүүдэд оршин байсан засгийн газруудын үйл ажиллагааг дэмжиж байсны илрэл болж байна.

2. Монголд одоо үйлчилж буй эрх зүйн тогтолцоо болон хуулиудад та сэтгэл хангалуун байдаг уу? эсхүл зарим нэгэн зүйлийг өөрчлөх хэрэгтэй юу? гэсэн асуултын **бүрэн сэтгэл хангалуун байдаг** гэж 4.1 хувь нь, **жижиг сажиг зүйлийг эс тооцвол сэтгэл хангалуун байдаг** гэж 22.2 хувь нь, **мэдэхгүй** гэж 2.3 хувь нь, **тийм ч сэтгэл хангалуун бус, зарим нэгэн өөрчилмөөр зүйл бий** гэж 56.7 хувь нь, **сэтгэл хангалуун бус, өөрчилмөөр зүйл их бий** гэж 14.3 хувь нь, хариулаагүй 0.4 хувь байна. Тэгэхээр ихэвчлэн хууль, эрх зүйн мэргэжилтэй, тухайн салбарт ажилладаг хүмүүс өнөөгийн эрх зүйн тогтолцоо, хуулиудад сэтгэл хангалуун бус өөрчлөх зүйл их байдаг хэмээн үздэг нь харагдаж байна.

3. Хуулиуд ерөнхийдөө ямар болсон гэж үздэг вэ? гэсэн асуултыг хариулсан байдлыг дараахь графикт үзүүлэв.

График 2.2



Эндээс үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь 1990 оноос хойш батлагдсан шинэчлэгдсэн хуулиудыг сайн, өмнөхөөсөө сайжирсан гэж дүгнэж байна.

4. Төр, хууль тогтоогчийн зүгээс хуулийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулах тал дээр хичээж ажилладаг уу? гэсэн асуултанд **тийм, их зүтгэл гаргадаг** гэж 17.3 хувь нь, **бага зэрэг хичээл зүтгэл гаргадаг** гэж 60.8 хувь нь, **иргэн хүн хуулийн утга агуулгыг ойлгох эсэх нь төрд хамаагүй** гэж 16.4 хувь нь, **энэ асуудал төрд огт хамаагүй** гэж 1.5 хувь нь, **мэдэхгүй** гэж 3.5 хувь нь тус тус хариулсан байна. Энэ асуултанд нийт оролцогчдын 0.6 хувь нь хариулаагүй алгассан байна. Судалгааны үр дүнгээс үзвэл төрөөс хууль, тогтоомжийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулах ажил хангалтгүй явагдаж байгаа нь харагдах бөгөөд энэ салбарт шууд болон дам хамаарах эдгээр хүмүүсийн 61 гаруй хувь нь төр бага зүтгэл гаргадаг гэж хариулсан нь давхар баталж байна.

5. Монголд хэт олон хууль байна уу? Хэт олон зүйлийг хуулиар зохицуулдаг уу? Хууль хэтэрхий цөөн байна уу? Хэт цөөн зүйлийг хуулиар зохицуулж байна уу? Эсхүл яг тохирсон гэж үздэг үү? гэсэн асуултанд 46.2 хувь нь **хэт олон хууль байдаг, хэт олон зүйлийг хуулиар зохицуулсан**, 15.5 хувь нь **хууль яг тохирсон**, 9.6 хувь нь **хэт цөөн хууль байдаг, хэт цөөн зүйлийг хуулиар зохицуулсан**, 24.9 хувь нь **мэдэхгүй** хэмээн тус тус хариулж, 3.8 хувь нь асуултыг алгассан байна. Эндээс үзвэл уг асуултанд хамгийн ойр байдаг судалгаанд оролцогчдын маань 46 гаруй хувь нь хэт олон хуультай, хэт олон асуудлыг зохицуулсан гэж үзэж байгаа нь Монголын нийгэм дэх хуулийн тоо олон, их зүйлийг зохицуулж байгааг харуулж байна.

6. Эрх зүйн болон хуулийн зохицуулалт ямар ч шаардлагагүйгээр ярвигтай байдаг гэж зарим хүн үздэг. Нөгөө хэсэг нь манай нийгэм болон хуулиар зохицуулагдах хүчин зүйлс нь ярвигтай учраас хуулиуд мөн ярвигтай байх ёстой гэж үздэг. Та ямар бодолтой байдаг вэ? гэсэн асуултанд **хуулиуд өөрөө ярвигтай учраас нийгэм, амьдралыг ярвигтай болгодог** гэж 16.4 хувь нь, **нийгмийн амьдралыг зохицуулах нь хэдийгээр хэцүү боловч хуулиуд бага зэрэг ч гэсэн хялбархан байж болмоор** гэж 43.9 хувь нь, **манай нийгэм өөрөө ярвигтай учраас хуулиуд ч гэсэн ярвигтай** гэж 18.1 хувь нь, **үүнийг дүгнэж хэлж мэдэхгүй** гэж 19.5 хувь нь тус тус хариулж 2.6 нь хариулаагүй байна. Эндээс үзэхэд хуулиуд ярвигтай учраас нийгмийг ярвигтай

болгодог, нийгмийг зохицуулах нь хэцүү боловч хууль хялбар байж болмоор гэсэн ойролцоо утгатай хариултуудыг нийт оролцогчдын 60.3 хувь нь сонгосон нь, үйлчилж буй хуулиуд ярвигтай байгаа нь харагдаж байна.

7. Хуулийг ямар ч нөхцөлд, хүн бүхэнд адил чанга хэрэглэх ёстой юу? Эсхүл тодорхой тохиолдолд (тухайлбал, санамсар болгоомжгүйгээр гэмт хэрэгт холбогдох, өвчин г. м) хөнгөрүүлэн хэрэглэх ёстой юу? гэсэн асуултын **хуулийг ямагт адил хэмжээгээр чанга хэрэглэх ёстой** гэсэн хариултыг 32.2 хувь нь, **онцгой тохиолдолд шүүгч хуулиар олгогдсон хөнгөрүүлэх нөхцөл байдлаас өөр хөнгөн хуулийг хэрэглэх боломжтой байх ёстой** гэсэн хариултыг 64.6 хувь нь, **мэдэхгүй** гэсэн сонголтыг 0.9 хувь нь тус тус хийж 2.3 нь хариулаагүй. Үүнээс үзэхэд санамсар болгоомжгүйгээр гэмт хэрэгт холбогдсон, өвчний улмаас ял эдлэх боломжгүй нөхцөлд шүүгчийг хөнгөн хууль хэрэглэхийг дэмжиж байгаа нь харагдаж байна.

8. Та хуулиудад өөрчлөлт орсныг хэрхэн мэдэж авдаг вэ? гэсэн задгай асуултанд хариулсныг багцлан хүснэгт болгон авч үзье.

Хүснэгт 4.1. Хуулиудад өөрчлөлт орсныг мэддэг байдал

Багцалсан хариу	Тоо	Хувь
Хэвлэл мэдээллийн хэрэгслээс	180	52.7
Ажлын шаардлагаар	15	4.4
Хууль уншиж	3	0.9
“Төрийн мэдээлэл” сэтгүүлээс	63	18.4
Сургалт явуулж буй байгууллагаас	1	0.3
Мэддэггүй	31	9.1
Хариулаагүй	49	14.3
Бүгд	342	100%

Энэ нь хуулийн байгууллагуудад ажилладаг хүмүүст албаны шугамаар хуулийн өөрчлөлтийн талаар мэдээлдэггүй нь харагдаж байна.

9. Таны нүдэнд туссан эрх зүйн дутагдалтай байдал болон шударга бус байдлыг юунаас үүдэлтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултыг өгөөд дараахь найман сонголтыг өгчээ. Ингээд найман хүчин зүйлээс алинаас нь шударга бус байдал үүдэлтэй гэж үзсэнийг хүснэгтээс үзье.

Хүснэгт 4.2. Эрх зүйн дутагдалтай байдал, шударга бус байдлыг юунаас үүдэлтэйг хариулсан байдал

Өгөгдсөн хариултууд	Тоо	Хувь
Хуулиуд алдаатай учраас	119	34.8
Шүүгчид муу ажилладаг учраас	83	24.3
Цагдаагийн байгууллага муу ажилладаг учраас	53	15.5
Төрийн албан хаагчид муу ажилладаг учраас	42	12.3
Одоогоор хангалттай сайн болоогүй байна, гэхдээ өмнө үүнээс ч дор байсан, цаашид сайжрах байх гэж бодож байна.	24	7.0
Урьд өмнө нь үүнээс илүү сайн байсан, улам муудах байх гэж бодож байна.	3	0.9
Тийм ч муу гэж бодохгүй байна.	8	2.3

Мэдэхгүй	1	0.3
Хариулаагүй	9	2.6
Бүгд	342	100%

10. Та санал нийлэхгүй байгаагийн улмаас өөрчлөх эсхүл бүр хүчингүй болгох хуулийн тодорхой заалт байдаг уу? гэсэн асуултанд хариулсныг дараахь хүснэгтээр үзүүлье.

Хүснэгт 4.3. Өөрчлөх, хүчингүй болгох хуулийн жагсаалт

Хариултууд	Тоо	Хувь
Эрүүгийн байцаан шийтгэх хууль	33	9.6
Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хууль	1	0.3
Усны тухай хууль	1	0.3
Газрын тухай хууль	10	2.9
Төрийн албаны тухай хууль	2	0.6
Гэр бүлийн тухай хууль	1	0.3
Байгаль орчны тухай хууль	3	0.9
Стандартчилал тохирлын үнэлгээний хууль	1	0.3
Үндсэн хууль	6	1.8
Татварын тухай хууль	1	0.3
Зохиогчийн эрхийн тухай хууль	3	0.9
Нийгмийн даатгалын тухай хууль	1	0.3
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль	2	0.6
Мэдэхгүй	103	30.1
Хариулаагүй	174	50.9
Бүгд	342	100%


Эндээс үзэхэд судалгаанд хамрагдсан, хуулийн байгууллагуудад ажиллагсдын 81 хувь нь өөрчлөх, хүчингүй болгох хуулиудыг нэрлэж чадахгүй байгаа нь ийм шаардлагатай хуулиуд тийм ч их биш байгааг харуулж байна. Гэхдээ дээрх нэр дурьдагдсан хуулиудаар тухайн хууль үйлчилдэг, хэрэглэгддэг мэргэжлийн хүмүүс болон нийт иргэдийн дунд хуулийн зүйл, заалтыг тодорхой дурьдсан сонголт бүхий асуулгыг дахин явуулах хэрэгтэй.

11. Эрх зүйн асуудалтай тулгарвал та өөрийгөө яаж дүгнэх вэ? гэсэн асуултанд судалгаанд хамрагдагсдын 26.6 хувь нь **өөртөө туслах чадвартай** гэж итгэлтэй хариулсан бол 63.2 хувь нь **зарим үед өөрөө өөртөө туслах чадвартай, гэхдээ бусдын зөвлөгөө, тусламж хэрэгтэй** гэж хариулжээ. Харин 6.7 хувь нь **өөрөө өөртөө тусалж бараг чадахгүй байх, ерөнхийдөө бусдын гар харна** гэсэн бол 0.3 хувь нь **нэг мөсөн хүний гарт орсон мэт байна** гэж, 0.6 хувь нь **мэдэхгүй** гэж хариулсан бөгөөд 2.6 хувь уг асуултанд хариулаагүй байна. Эндээс үзвэл мэргэжлийн онцлог тодорхой харагдаж байна. Хууль, эрх зүйн салбарт ажиллагсад эрх зүйн асуудалтай тулгарвал тийм ч хүнд байдалд орохгүй нь илт байна.

12. Бидний өдөр тутмын амьдралтай холбоотой хуулиудын талаарх мэдлэгээ та хэрхэн дүгнэх вэ? /Тухайлбал байрны түрээсийн эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй, хэрэглэгчийн эрх зүй/ гэсэн асуултанд **энэ талаархи миний мэдлэг ер нь сайн** гэж 12.9 хувь нь, **ерөнхийдөө мэдэх байх гэж бодож байна** гэж 56.1 хувь нь, **бага мэдлэгтэй, гэхдээ хэнээс тусламж, зөвлөгөө авахаа мэднэ** гэж 25.7 хувь нь, **энэ тухай огт мэдлэг байхгүй, хэнд хандахаа ч мэдэхгүй** гэж 2.0 хувь нь, **мэдэхгүй** гэж 0 хувь нь хариулсан ба 3.2 хувь нь хариулаагүй байна

- Хуулиуд эсхүл эрх зүйн ямар нэг салбарыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна уу? гэсэн асуултын сонголтуудад хариулсан байдлыг дараахь графикаар үзүүлэв.

График 2.3




Харин дээрхи асуултын задгай хэсэгт сайжруулах шаардлагатай хуулиуд, эрх зүйн салбарыг дурьдсан байдлыг дараахь хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 4.4. Сайжруулах шаардлагатай хуулиуд, эрх зүйн салбарыг нэрлэсэн байдал

Хариулт	Тоо	Хувь
Эрүүгийн хууль	30	8.8
Цагдаагийн байгууллага	11	3.2
Мэдээлэл сурталчилгаа	2	0.6
Шүүх	17	5.0
Төрийн бодлого	1	0.3
Эрх зүйн салбар	8	2.3
Компанийн тухай хууль	4	1.2
Татварын багц хууль	4	1.2
Улсын мэргэжлийн хяналтын газар	2	0.6
Улсын их хурал	1	0.3
Төсвийн тухай хууль	3	0.9
Нийгэм, эдийн засгийн салбар	2	0.6
Авто тээврийн хууль	1	0.3
Үндсэн хууль	3	0.9
Захиргааны эрх зүй	7	2.0
Хэвлэлийн эрх чөлөө	2	0.6
Гаалийн тухай хууль	3	0.9
Боловсролын салбар	1	0.3
Гэр бүлийн хууль	1	0.3
Байгаль орчны тухай хууль	2	0.6
Ашигт малтмалын тухай хууль	1	0.3

Нийгмийн даатгал	1	0.3
Хариулаагүй	235	68.7
Бүгд	342	100%

График 2.4



Эндээс үзвэл хуульд итгэх итгэл алдраагүй байгаа бөгөөд сайн хуулиуд шаардлагатай байгааг харж болно.

Хүснэгт 4.5. Танд эрх зүйн болон хуулийн зөвлөгөө хэрэгтэй юу?

Хариулт	Тоо	Хувь
Тийм эрх зүйн талаархи зөвлөгөө	108	31.6
Тийм хуулийн талаархи зөвлөгөө	190	55.6
Үгүй, хэрэггүй	30	8.8
Мэдэхгүй	2	0.6
Хариулаагүй	12	3.5
Бүгд	342	100%

Үүнээс үзэхэд хууль, эрх зүйн салбарт ажиллагсдад хуулийн болон эрх зүйн зөвлөгөө ихээхэн шаардлагатай байгаа нь харагдаж байна. Тиймээс энэ салбарын хүмүүсийн дунд давтан болон мэргэжил дээшлүүлэх сургалтууд зохион байгуулах, нэгдсэн мэдээллээр хангах ажлыг эрчимтэй явуулах хэрэгцээ байна гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

Хүснэгт 4.6. Захиргааны байгууллагын шийдвэрт та гомдол гаргаж байсан уу?

Хариулт	Тоо	Хувь
Тийм	28	8.2
Үгүй	292	85.4
Мэдэхгүй	10	2.9
Хариулаагүй	12	3.5
Бүгд	342	100%

Дээрхи асуултанд гомдол гаргаж байсан гэж хариулсан иргэдийн задгай асуултанд хариулсан байдлыг дараахь хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 4.7. Гомдол гаргаж байсан захиргааны байгууллагын шийдвэр

Хариулт	Тоо	Судалгаанд оролцсон 342 иргэнтэй харьцуулсан хувь
Ажлаас хууль бусаар халах	2	0.6
Гэрч	1	0.3
Аймгийн засаг даргын шийдвэрт	1	0.3
Мэргэжлийн хяналтын албанд	1	0.3
Байгууллагын даргад	1	0.3
Нийслэлийн газрын албанд	3	0.9
Гаалийн байгууллагад	1	0.3
Шүүхийн ерөнхий зөвлөлд	1	0.3
Алгассан	302	88.3
Хариулаагүй	29	8.5
Бүгд	342	100%


Хэр амжилт олсныг дараахь хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4.8. Гомдол гаргаад амжилт олсон байдал

Хариулт	Тоо	Хувь
Амжилт олсон	14	4.1
Амжилт олоогүйгээр үл барам энэ нь надад муугаар нөлөөлсөн	6	1.8
Амжилт олоогүй	7	2.0
Мэдэхгүй	1	0.3
Алгассан	302	88.3
Хариулаагүй	12	3.5
Бүгд	342	100%

- Албан газрууд урд өмнөхөөсөө хэр сайн ажиллаж байгаа талаар дараахь графикт үзүүлье.

График 2.5



Үүнээс үзвэл албан газрууд урд өмнөхөөсөө муу ажиллаж байгаа нь илт байна.


13. Хүснэгт 4.9. Та өөрт холбогдох ямар нэг асуудлыг шүүхээр шийдвэрлүүлж байсан уу?

Хариулт	Тоо	Хувь
Тийм	81	23.7
Үгүй	251	73.4
Хариулаагүй	10	2.9
Бүгд	342	100%

14. Та өөрийнхөө зөв гэдэгт бүрэн итгэлтэй байгаад шүүх үүнийг баталгаажуулна гэдэгт эргэлздэг үү? гэсэн асуултанд **үүнд санаа зовдоггүй, би хуулийн байгууллага, шүүгч нарт бүрэн итгэдэг** гэж 21.3 хувь нь, **шүүх зуун хувь шударга шийдвэр гаргана гэдэгт бага зэрэг эргэлздэг** гэж 36.8 хувь нь, тухайн **шүүгч болон прокуророос их зүйл хамаардаг учраас нэлээд их эргэлздэг** гэж 36.0 хувь нь, **мэдэхгүй** гэж 4.1 хувь нь хариулсан бөгөөд уг асуултанд хариулалгүйгээр 1.8 хувь нь алгассан байна. Эндээс үзвэл хууль, эрх зүйн салбарт ажиллагсдын дунд шүүхэд итгэх итгэл сул байгаа нь харагдаж байна.

15. Шүүхэд очилгүй талуудыг хооронд нь эвлэрүүлэх, зөвлөгөө өгөх газруудын үүргийг хэр чухал гэж үздэг вэ? /Тухайлбал байрны түрээсийн эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй, хэрэглэгчийн эрх зүй/ Хариултыг графикаар авч үзвэл:

График 2.6



Эндээс үзэхэд шүүхэд очилгүй талуудыг эвлэрүүлэх, зөвлөгөө өгөх газрууд шаардлагатай нь харагдаж байна. Үүнийг хууль, эрх зүйн салбарт ажилладаг хүмүүс маш идэвхтэй дэмжиж байгаа юм байна.

16. Шүүхийн шийдвэр гаргаж буй практикаас харахад манай хуулиуд бүхий л зөрчилдөөнийг урьдчилан харж зохицуулалт хийгээгүй байдаг. Иймээс шийдвэр гаргахад нь шүүгчид тодорхой эрх чөлөө олгосон байдаг. Та ямар бодолтой байна вэ? гэсэн асуултанд **шүүх болон шүүгч нар энэ эрх чөлөөгөө шударга ёсны төлөө ашигладаг гэдэгт итгэдэг** гэж 25.7 хувь нь, **гарч болохуйц бүхий л зөрчилдөөнийг хууль тогтоогч зохицуулж өгөх ёстой. Ингэснээрээ шүүгчдийн шийдвэр гаргах эрх чөлөөг багасгах юм** гэж 50.3 хувь нь, **мэдэхгүй** гэж 12.0 хувь нь хариулсан бол 12.0 хувь нь энэ асуултыг алгассан байна. Энэ нь шүүгчдийн эрх чөлөөг багасгах хэрэгцээ байгааг харуулах бөгөөд үүний цаана шүүгчид итгэх итгэл бага байгаа нь мэдрэгдэж байна.

17. Бидэнд эрх зүй, хуулийн зохицуулалт заавал хэрэгтэй юу? Эсхүл хүмүүс хоорондоо зохицоод байж болох уу, өөрөөр хэлбэл “шүүгчийн хэрэг байхгүй” гэж үзэж байна уу? гэсэн асуултанд 94.2 хувь нь **бидэнд эрх зүй, хууль заавал хэрэгтэй** гэсэн хариуг сонгосон бол 1.8 хувь нь **эрх зүй, хуульгүйгээр хүмүүс хоорондоо зохицоод явах нь магадгүй дээр** гэсэн хариуг сонгож, 1.8 хувь нь **мэдэхгүй** гэсэн бол 2.3 хувь нь хариулаагүй. Асуулгын дүнгээс үзвэл хууль, эрх зүйн зохицуулалт заавал хэрэгтэй нь илт байна.

18. Монгол Улсын Үндсэн хуульд ард түмэн ардчилсан сонгуулиар сонгогдсон УИХ-аар дамжуулан төрийн эрхийг барина хэмээн заасан байдаг Та дараахь өгүүлбэрүүдийг хэрхэн үзэж байна вэ? гэсэн асуултын үр дүнгүүдийг хүснэгтүүдээр үзүүлье.

Хүснэгт 4.10. Би УИХ дахь өөрийн сонгосон төлөөлөгчдөө сэтгэл хангалуун байдаг.

Хариулт	Тоо	Хувь
Яг үнэн	8	2.3
Ер нь үнэн	84	24.6
Ер нь худлаа	117	34.2
Ерөөсөө худлаа	74	21.6
Мэдэхгүй	46	13.5

Хариулаагүй	13	3.8
Бүгд	342	100%

Хүснэгт 4.11. УИХ-аас иргэдийн сэтгэлд нийцдэггүй хууль батлан гаргадаг.

Хариулт	Тоо	Хувь
Яг үнэн	30	8.8
Ер нь үнэн	171	50.0
Ер нь худлаа	69	20.2
Ерөөсөө худлаа	12	3.5
Мэдэхгүй	46	13.5
Хариулаагүй	14	4.1
Бүгд	342	100%

Хүснэгт 4.12. УИХ буюу УИХ-ын гишүүд бидэнд үүрэг ногдуулахаас бус бидний эрхийн талаар санаа тавьдаггүй.

Хариулт	Тоо	Хувь
Яг үнэн	41	12.0
Ер нь үнэн	173	50.6
Ер нь худлаа	60	17.5
Ерөөсөө худлаа	14	4.1
Мэдэхгүй	41	12.0
Хариулаагүй	13	3.8
Бүгд	342	100%

Хүснэгт 4.13. УИХ-ын гишүүд жирийн иргэдийн бодол санаа, хүсэл зоригт их анхаарал тавьдаг

Хариулт	Тоо	Хувь
Яг үнэн	7	2.0
Ер нь үнэн	66	19.3
Ер нь худлаа	151	44.2
Ерөөсөө худлаа	49	14.3
Мэдэхгүй	57	16.7
Хариулаагүй	12	3.5
Бүгд	342	100%

Хүснэгт 4.14. Хууль хэрхэн батлагдан гарсныг жирийн иргэд ойлгодоггүй.

Хариулт	Тоо	Хувь
Яг үнэн	109	31.9
Ер нь үнэн	174	50.9
Ер нь худлаа	21	6.1
Ерөөсөө худлаа	10	2.9
Мэдэхгүй	16	4.7
Хариулаагүй	12	3.5
Бүгд	342	100%

Хүснэгт 4.15. Монгол Улсын эрх зүйн бүтцийг би дараахь байдлаар тодорхойлж чадна. Би ч гэсэн хуулийг яг адилхнаар батлан гаргах байсан.

Хариулт	Тоо	Хувь
Яг үнэн	7	2.0
Ер нь үнэн	86	25.1
Ер нь худлаа	55	16.1
Ерөөсөө худлаа	17	5.0
Мэдэхгүй	142	41.5
Хариулаагүй	35	10.2
Бүгд	342	100%

Хүснэгт 4.16. Эрх зүйн тогтолцоо тодорхой ач холбогдолтой байх талаар төрийн зүгээс их анхаардаг.

Хариулт	Тоо	Хувь
Яг үнэн	37	10.8
Ер нь үнэн	170	49.7
Ер нь худлаа	45	13.2
Ерөөсөө худлаа	4	1.2
Мэдэхгүй	66	19.3
Хариулаагүй	20	5.8
Бүгд	342	100%

Эдгээр үр дүнгүүдээс үзэхэд иргэд өөрийн төлөөлөл болгон сонгосон УИХ болон УИХ-ын гишүүдэд итгэл алджээ.

19. Доор “эрх зүй” хэмээх ухагдахуунтай ямар нэг хэмжээгээр холбоотой ойлголтуудыг жагсаасан. Монголын практик амьдралд “эрх зүйтэй” нягт холбоотой гэж үзсэн гурван ойлголтыг тэмдэглэнэ үү? гэсэн асуултын 14 сонголтын давхардсан тоо, хувь, давхардсан хувийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4.17. Монголын практик амьдралд “эрх зүйтэй” нягт холбоотой ойлголтуудыг сонгосон байдал

Өгөгдсөн сонголтууд	Давхардсан тоо	Хувь	Давхардсан хувь
Шударга ёс	227	25.1	73.2
Олон нийтийн аюулгүй байдал	64	7.1	20.6
Эрх чөлөө	157	17.3	50.6
Хэв журам	55	6.1	17.7
Захиргааны албан газрууд	34	3.8	11.0
Шүүх	64	7.1	20.6
Цагдаа	30	3.3	9.7
Эрх зүйн аюулгүй байдал	70	7.7	22.6
Адил тэгш байх зарчим	143	15.8	46.1
Зөрчлийг шийдэх	43	4.8	13.9
Бусдын гарт орсон мэт байх	6	0.7	1.9
Албадлага	8	0.9	2.6
Ухаан мэдрэл алдсан мэт	2	0.2	0.6

байдал			
Мэдэхгүй	2	0.2	0.6
Бүгд	905	100%	291.9

Ямар ойлголтуудыг “эрх зүй”-тэй холбон ойлгох ёстой гэж та үзэж байна вэ? гэсэн асуултын 14 сонголтын сонгосон хувийг дараахь графикаар үзүүлье. Мөн давхардсан тоо, хувь, давхардсан хувийг хүснэгтээр үзүүлэв.

График 2.7




Хүснэгт 4.18. Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтуудаас сонгосон байдал

Өгөгдсөн сонголтууд	Давхардсан тоо	Хувь	Давхардсан хувь
Шударга ёс	192	24.2	71.4
Олон нийтийн аюулгүй байдал	55	6.9	20.4
Эрх чөлөө	123	15.5	45.7
Хэв журам	46	5.8	17.1
Захиргааны албан газрууд	28	3.5	10.4
Шүүх	60	7.6	22.3
Цагдаа	31	3.9	11.5
Эрх зүйн аюулгүй байдал	82	10.4	30.5
Адил тэгш байх зарчим	121	15.3	45.0
Зөрчлийг шийдэх	42	5.3	15.6
Бусдын гарт орсон мэт байх	2	0.3	0.7
Албадлага	9	1.1	3.3
Ухаан мэдрэл алдсан мэт	1	0.1	0.4

байдал			
Бүгд	792	100%	294.4

20. Бусад хүмүүстэй ямагт шударга харьцах нь эцсийн эцэст өөрт нь эерэг үр дүн авчирдаг гэж үздэг үү? Эсхүл ингэснээр хүн өөрөө ихэнхдээ тэнэг байдалд ордог уу? гэсэн асуултанд хариулсан байдлыг графикаар үзүүлье.

График 2.8



Эндээс үзэхэд хуулийн салбарт ажиллаж буй иргэдийн дийлэнх хувь нь шударга ёсыг эрхэмлэн дээдэлдэг нь харагдаж байна. Гэхдээ шударга байх зарчмыг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан баримталдаг 10.8 хувь нь хүмүүстэй шударга харьцах нь өнөөгийн нийгэмд тохирохгүй гэж үзжээ. Энэ нь хуулийн салбарт ажилладаг иргэдийн ажлын онцлогийг илэрхийлнэ.

21. Захиргааны байгууллага, албан хаагчийн шийдвэрийг хууль бус гэж үзвэл шүүхэд хандах боломж иргэдэд олгогдсон. Та үүнийг юу гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд **энэ нь надад эерэгээр нөлөөлнө** гэж 49.7 хувь нь, **захиргааны албан хаагч эсхүл захиргааны байгууллагын шийдвэрт гомдол гаргах нь эцэстээ надад сөрөг үр дагавар авчирна** гэж 7.3 хувь нь, **надад ямар ч нөлөө байхгүй** гэж 21.9 хувь нь, **мэдэхгүй** гэж 12.9 хувь нь хариулсан бөгөөд 8.2 хувь нь энэ асуултанд хариулаагүй байна. Энэ үр дүн нь Монголд шинээр байгуулагдсан захиргааны хэргийн шүүхэд судалгаанд оролцогчид нааштай хандаж, дэмжиж байгааг харуулж байна.

22. Та өөрийнхөө нийгмийн идэвхийг хэрхэн дүгнэх вэ? гэсэн асуултын сонгох хариулт тав байсан. Үүнээс шивэлтэнд тавыг сонгосон болно.

Хүснэгт 4.19. Нийгэм, улс төрийн идэвхийг үнэлсэн байдал

Өгөгдсөн сонголтууд	Тоо	Хувь
Сонгуульд тогтмол оролцдог, сонгуулийг өнгөрөөхгүйг боддог	84	24.6
Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцдог	71	20.8
Улс төрд их сонирхолтой	8	2.3

Найз нөхөд танилуудтайгаа улс төрийн тухай их ярилцдаг	68	19.9
Зөв гэсэн итгэл үнэмшилтэй бол улс төрийн жагсаал цуглаанд оролцоно	87	25.4
Асуултанд хариулаагүй	24	7
Бүгд	342	100%

23. Сүүлийн сонгуулиудад оролцсон байдал: Та хамгийн сүүлийн сонгуульд оролцсон уу? гэсэн асуулгын үр дүнг дараахь хүснэгтүүдэд үзүүлье.

Хүснэгт 4.20. УИХ-ын сонгууль

Хариулт	Тоо	Хувь
Тийм	287	83.9
Үгүй	26	7.6
Хариулт байхгүй	5	1.5
Алгассан	24	7.0
Бүгд	342	100%

Хүснэгт 4. 21. УИХ-ын сонгуульд оролцсон хуулийн салбарт ажиллагсдын санал өгсөн байдал

Нам, эвсэлийн нэр	Тоо	Хувь
МАХН	114	33.3
“Эх орон-Ардчилал” эвсэл	52	15.3
Бусад нам	24	7.0
Хариулаагүй	121	35.4
Алгассан	31	9.1
Бүгд	342	100%

Хүснэгт 4.22. Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон байдал

Хариулт	Тоо	Хувь
Тийм	280	81.9
Үгүй	20	5.8
Хариулаагүй	42	12.3
Бүгд	342	100%

Хүснэгт 4.23. Орон нутгийн сонгуульд оролцсон байдал

Хариулт	Тоо	Хувь
Тийм	190	55.6
Үгүй	55	16.1
Хариулт байхгүй	10	2.9
Алгассан	87	25.4
Бүгд	342	100%

Эндээс үзэхэд сүүлд болсон УИХ, Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын идэвхи өндөр байсан ба харин орон нутгийн сонгуульд судалгаанд оролцогчдын идэвхи сул байсан нь харагдаж байна.

Ерөнхий дүгнэлт

1. 1989-1990 онд Монгол оронд өрнөсөн ардчилсан тайван хувьсгалын дараа Монгол Улсын байдал бүхэлдээ хэрхэн өөрчлөгдсөн талаар судалгаанд оролцсон иргэдийн 60 шахам хувь, хуулийн салбарт ажиллагсдын 80 орчим нь сайжирсан гэж хариулсан нь иргэдийн ирээдүйдээ итгэх итгэл, тухайн жилүүдэд засгийн эрхэнд байсан улс төрийн нам, хүчнүүдийн бодлого, мөрийн хөтөлбөрийг дам утгаараа дэмжиж байгаагийн илрэл юм.

2. Монголд одоо үйлчилж буй эрх зүйн тогтолцоо болон хуулиудын зарим нэгийг өөрчлөх хэрэгтэй гэж 57 орчим хувь нь, өөрчилмөөр зүйл их бий гэж 14 гаруй хувь нь үзсэн нь хууль, эрх зүйн мэргэжил давамгайлсан, тухайн салбарт ажилладаг хүмүүс өнөөгийн эрх зүйн тогтолцоо, хуулиудад сэтгэл хангалуун бус байгаагийн илрэл бөгөөд эрх зүйн шинэтгэлийг цаашид далайцтай явуулах шаардлагатайг харуулж байна.

3. Монгол оронд шинээр батлагдан гарч буй хуулиуд ерөнхийдөө өмнөхөөсөө сайжирсан гэсэн хариуг иргэдийн 50 шахам хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 68 орчим хувь өгсөн нь шинэчлэгдэн батлагдсан хуулиудын талаар олон нийт болон хуулийн салбарынхан эерэг санаа бодолтой, сэтгэл хангалуун байгаагийн илрэл болж байна.

4. Төрийн зүгээс хуулийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулах тал дээр муу ажилладаг гэсэн дүнг судалгаанд оролцсон иргэд өгчээ гэж үзэж болохоор байна. Төр, ард түмэндээ хуулийн утга, агуулга, зорилго, шаардлагыг ойлгуулах гэж бага зэрэг хичээл зүтгэл гаргадаг хэмээн нийт судалгаанд хамрагдагсдын 50 орчим хувь үзсэн бол иргэн хүн хуулийн утга агуулгыг ойлгох эсэх нь төрд хамаагүй байдаг гэж 20 орчим хувь үзсэнээс илэрхий.

5. Төр, хууль тогтоогчийн зүгээс хуулийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулах тал дээр их зүтгэл гаргадаг хэмээн хуулийн салбарт ажиллагсдын 17 гаруй хувь нь, бага зэрэг зүтгэл гаргадаг гэж 61 гаруй хувь хариулсан нь төрөөс хууль, тогтоомжийн утга агуулга, зорилго, шаардлагыг иргэдэд ойлгуулах ажил хангалтгүй явуулдаг нь харагдаж байна. Хуулийг сурталчлан таниулах ажилд шууд болон дам замаарах эдгээр хүмүүсийн дүгнэлт бодитой байх нь гарцаагүй.

6. Монголд хэт олон хууль үйлчилж, олон асуудлыг зохицуулдаг гэдэгтэй жирийн иргэдийн 30 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 46 гаруй хувь санал нийлсэн бол жирийн иргэдийн 15 орчим хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 6 орчим хувь нь хууль яг тохирсон, жирийн иргэдийн 20 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 10 орчим хувь нь хэт цөөн хууль үйлчилж цөөн зүйлийг хуулиар зохицуулсан, жирийн иргэдийн 30 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 25 орчим хувь нь мэдэхгүй хэмээн тус тус хариулснаас үзэхэд өнөөгийн эрх зүйн салбарын зарим хуулиудыг тодорхой болгох нь зүйтэй гэсэн дүгнэлтэнд хүргэж байгаа бөгөөд нийт иргэдийн эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалт явуулах шаардлагатай болохыг харуулж байна.

7. Хуулиуд ярвигтай учраас нийгэм, амьдралыг ярвигтай болгодог гэсэн сонголтыг жирийн иргэдийн 30 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 16 гаруй хувь нь, нийгмийн амьдралыг зохицуулах нь хэдийгээр хэцүү боловч хуулиуд бага зэрэг ч гэсэн хялбархан байж болмоор гэсэн сонголтыг жирийн иргэдийн 35 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 44 орчим хувь нь, манай нийгэм ярвигтай учраас хуулиуд ч гэсэн ярвигтай гэж жирийн иргэдийн 10 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 18 гаруй хувь хариулсан байна. Эндээс үзэхэд хуулиуд ярвигтай учраас нийгмийг ярвигтай болгодог, хуулиуд хялбар байж болмоор, нийгэм өөрөө хуулиудыг ярвигтай болгодог гэсэн ойролцоо утгатай хариултуудыг нийт оролцогчдын дийлэнх сонгосон нь үйлчилж буй хуулиудыг сурталчлах, таниулах ажил дутмаг байгаа нь харагдаж байна.

8. Хуулийг ямагт адил хэмжээгээр чанга хэрэглэх ёстой гэж жирийн иргэдийн 36 хувь, хуулийн салбарт ажиллагсдын 32 гаруй хувь нь, онцгой тохиолдолд шүүгч хуулиар олгогдсон хөнгөрүүлэх нөхцөл байдлаас өөр хөнгөн хуулийг хэрэглэх боломжтой байх ёстой гэж жирийн иргэдийн 53 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 65 орчим хувь нь үзжээ. Энэ нь санамсар болгоомжгүйгээр гэмт хэрэгт холбогдсон, өвчний улмаас ял эдлэх боломжгүй нөхцөлд шүүгчийг хөнгөн хууль хэрэглэхийг дэмжиж байгаагийн илрэл юм.

9. Судалгаанд оролцсон хүмүүсийн дийлэнхи буюу 62 орчим хувь нь хуулиудад өөрчлөлт орсныг хэвлэл мэдээллийн хэрэгслээс мэддэг бол 20 орчим хувь нь ажлын шугамаар мэддэг гэсэн нь жирийн иргэдийн ажил, төрөлд хуулийн зүйл, заалт төдий л хэрэг болоод байдаггүй ч иргэд хуулийн өөрчлөлтийн тухай мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хангалттай олж авдаг болох нь мэдэгдэж байна.

10. Хуулиудад өөрчлөлт орсныг хуулийн салбарт ажиллагсдын 53 орчим хувь нь радио, телевиз, сонин зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээс мэдэж авдаг бол 4 гаруй хувь нь ажлын шаардлагаар, 0.9 хувь хууль уншиж буюу өөрийн санаачлагаар, 18 гаруй хувь нь “Төрийн мэдээлэл” сэтгүүлээс, 0.3 хувь нь сургалт явуулж буй байгууллагаас хэмээн хариулсан. Энэ нь хууль, эрх зүйн салбарт ажилладаг хүмүүст албаны шугамаар хуулийн өөрчлөлтийн талаархи мэдээлэл хангалттай очдоггүйг харуулж байгаа бөгөөд гэхдээ хуулиудад өөрчлөлт орсныг ямар ч байсан мэддэг нь харагдаж байна.

11. Эрх зүйн дутагдалтай байдал болон шударга бус байдал юунаас үүдэлтэй вэ? гэсэн асуултын найман сонголтоос жирийн иргэдийн хариултыг үзвэл:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг муу гэсэн сонголт хамгийн олон буюу давхардсан хувиар 37 гаруй хувь;
2. Одоо мөрдөгдөж буй хуулиудыг муу, алдаатай гэсэн сонголт давхардсан хувиар 35 гаруй хувь;
3. Одоогоор хангалттай сайн болоогүй байна, гэхдээ өмнө үүнээс ч дор байсан, цаашид сайжрах байх гэж бодож байна гэсэн сонголт давхардсан хувиар 34 орчим хувь;
4. Шүүгчдийг муу ажилладаг гэж давхардсан хувиар 31 гаруй хувь;
5. Төрийн албан хаагчид муу ажилладаг гэж давхардсан хувиар 29 орчим

хувь нь сонгосон байгаа нь зарим хуулиуд алдаатай, түүнийг хэрэгжүүлэн ажилладаг цагдаа, шүүх, төрийн байгууллагуудын муу ажилладгаас үүдэлтэй гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.

Харин хуулийн салбарт ажиллагсдын хувьд хуулиуд алдаатайгаас үүдэлтэй гэж 35 орчим хувь нь, шүүх, цагдаа, төрийн албан хаагчид муу ажилладгаас үүдэлтэй гэж 52

гаруй хувь үзсэн нь шүүх, цагдаа, төрийн албан хаагчдыг тодорхой хэмжээгээр төлөөлж буй судалгаанд оролцогчид маань ийм хариулт өгсөн нь дээрхи дүгнэлтийг улам бататгаж байна.

12. Судалгаанд оролцогчид санал нийлэхгүй байгаагийн улмаас өөрчлөх эсхүл хүчингүй болгох хуулиудаар дараахь хуулиудыг нэрлэжээ.

Хүснэгт 5.1. Өөрчлөх, хүчингүй болгох хуулиуд

Хуулиуд	Тоо	Хувь
Боловсролын тухай хууль	8	0.9
Банкны тухай хууль	3	0.4
Нийгмийн даатгалын тухай хууль	1	0.1
Газар өмчлөлийн хууль	10	1.2
Эрүүгийн хууль	22	2.6
Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	2	0.2
Сонгуулийн тухай хууль	2	0.2
Ойн тухай хууль	1	0.1
Үндсэн хууль	1	0.1
Хөдөлмөрийн тухай хууль	1	0.1
Улс төрийн намуудын тухай хууль	1	0.1
Ашигт малтмалын тухай хууль	9	1.1
Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль	2	0.2
Иргэний хууль	2	0.2
Авилгалын тухай хууль	1	0.1
Эрүүл мэндийн тухай хууль	1	0.1

Харин хуулийн салбарт ажилладаг судалгаанд оролцогчид маань өөрчлөх, хүчингүй болгохоор нэрлэсэн хуулиудын тоог хувийн хамт доорхи хүснэгтээр үзүүлье.

Хүснэгт 5.2. Өөрчлөх, хүчингүй болгох хуулиуд

Хариултууд	Тоо	Хувь
Эрүүгийн байцаан шийтгэх хууль	33	9.6
Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хууль	1	0.3
Усны тухай хууль	1	0.3
Газрын тухай хууль	10	2.9
Төрийн албаны тухай хууль	2	0.6
Гэр бүлийн тухай хууль	1	0.3
Байгаль орчны тухай хууль	3	0.9
Стандартчилал, тохирлын үнэлгээний хууль	1	0.3
Үндсэн хууль	6	1.8
Татварын тухай хууль	1	0.3
Зохиогчийн эрхийн тухай хууль	3	0.9
Нийгмийн даатгалын тухай хууль	1	0.3
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль	2	0.6
Мэдэхгүй	103	30.1
Хариулаагүй	174	50.9
Бүгд	342	100%

Жирийн иргэдийн дөнгөж 7.7 хувь нь дээрхи хуулиудыг нэрлэсэн бөгөөд үлдсэн хувь нь байхгүй, мэдэхгүй эсхүл хариулаагүй байна. Хуулийн салбарт ажиллагсдын 81 хувь нь өөрчлөх, хүчингүй болгох хуулиудыг нэрлээгүй байна. Эндээс үзвэл өөрчлөх, бүр алга болгох хуулиуд бага байдаг нь харагдаж байна. Гэхдээ дээр дурьдагдсан бүх хуулиудаар хууль үйлчилдэг, хэрэглэдэг мэргэжлийн хүмүүс болон нийт иргэдийн дунд хуулийн зүйл, заалтыг тодорхой дурьдсан сонголт бүхий асуулгыг дахин явуулах ёстойг харуулж байна. Дээрхи хуулиуд нь ихэвчлэн мэргэжлийн онцлогийг агуулсан нь ийм дүгнэлт хийхэд хүргэж байна. Мөн өөрчлөх, хүчингүй болгохоор санал болгосон хуулиудаас хамгийн их хувьтай нь Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль байгааг давхар тэмдэглэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ хууль нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байна гэж хуулийг хэрэглэдэг, хууль үйлчилдэг төлөөллүүд үзсэн байна.

13. Эрх зүйн асуудалтай тулгарвал жирийн иргэдийн 17 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 27 орчим хувь нь өөртөө туслах чадвартай, жирийн иргэдийн 57 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 63 гаруй хувь нь зарим үед өөрөө өөртөө туслах чадвартай, гэхдээ бусдын зөвлөгөө, тусламж хэрэгтэй, жирийн иргэдийн 16 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 7 орчим хувь нь өөртөө тусалж бараг чадахгүй байх, ерөнхийдөө бусдын гар харна, жирийн иргэдийн 3 орчим хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 0.3 хувь нь нэг мөсөн хүний гарт орсон мэт байна гэх мэтээр хариулжээ. Эндээс жирийн иргэд болон хуулийн салбарт ажиллагсдын ялгаа харагдаж байна. Хуулийн салбарт ажиллагсад эрх зүйн асуудалтай тулгарвал тийм ч хүнд байдалд орохгүй бол жирийн хүмүүсийн хувьд эрх зүйн асуудалтай тулгарвал өөртөө хэрэгтэй зохих хуулийн мэдлэггүй байгаа нь харагдаж байна.

14. Өдөр тутмын амьдралтай холбоотой хуулиудын талаархи мэдлэгээ иргэдийн 12 гаруй хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 13 орчим хувь нь миний мэдлэг ер нь сайн, жирийн иргэдийн 28 орчим хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 56 хувь нь ерөнхийдөө мэдэх байх, жирийн иргэдийн 41 гаруй хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 26 хувь нь бага мэдлэгтэй, гэхдээ хэнээс тусламж, зөвлөгөө авахаа мэднэ гэж хариулсан бол жирийн иргэдийн 11 гаруй хувь нь энэ тухай мэдлэг огт байхгүй, хэнд хандахаа ч мэдэхгүй буюу өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон 10 хүн тутмын 1 нь өдөр тутмын амьдралд холбогдох хуулийн талаар огт мэдлэггүйгээ шууд илэрхийлжээ. Энэ нь өдөр тутмын амьдралд холбогдох хуулийн мэдлэг жирийн хүмүүст сул байгааг харуулж байна.

15. Хуулиуд эсхүл эрх зүйн ямар нэг салбарыг сайжруулах шаардлагатай гэж хуулийн салбарт ажиллагсдын 44 орчим хувь нь үзэж байхад мэдэхгүй гэсэн 26 хувь, хариулаагүй 28 орчим хувь байгаа нь ийм шаардлага байгааг нотолж байна.

Ингээд өөрчлөх шаардлагатай хуулиуд эсхүл эрх зүйн салбарыг нэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 5.3. Өөрчлөх шаардлагатай хуулиуд эсхүл эрх зүйн салбар

Хариулт	Тоо	Хувь
Эрүүгийн хууль	30	8.8
Цагдаагийн байгууллага	11	3.2
Мэдээлэл сурталчилгаа	2	0.6
Шүүх	17	5.0
Төрийн бодлого	1	0.3
Эрх зүйн салбар	8	2.3

Компанийн тухай хууль	4	1.2
Татварын багц хууль	4	1.2
Улсын мэргэжлийн хяналтын газар	2	0.6
Улсын их хурал	1	0.3
Төсвийн тухай хууль	3	0.9
Нийгэм, эдийн засгийн салбар	2	0.6
Авто тээврийн хууль	1	0.3
Үндсэн хууль	3	0.9
Захиргааны эрх зүй	7	2.0
Хэвлэлийн эрх чөлөө	2	0.6
Гаалийн тухай хууль	3	0.9
Боловсролын салбар	1	0.3
Гэр бүлийн тухай хууль	1	0.3
Байгаль орчны тухай хууль	2	0.6
Ашигт малтмалын тухай хууль	1	0.3
Нийгмийн даатгал	1	0.3
Хариулаагүй	235	68.7
Бүгд	342	100%

16. Монголын ард түмний амьдрал сайжрахад сайн хуулиуд нэмэр болно гэж жирийн иргэдийн 80 орчим хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 95 гаруй хувь хариулсан нь сайн хууль хэрэгтэй байгаа, иргэд болон хуулийн салбарт ажиллагсдын хуульд итгэх итгэл хүчтэй байгааг илэрхийлж байна.

17. Эрх зүйн болон хуулийн зөвлөгөө хэрэгтэй юу гэсэн асуултанд хэрэггүй гэж 17 орчим хувь, мэдэхгүй гэж 40 гаруй хувь нь хариулжээ. Гэхдээ асуулгын сонголтонд хэрэгтэй гэсэн хувилбар байгаагүй боловч хэрэгтэй гэж 21 орчим хувь үзсэн нь хүмүүсийн дунд хууль, эрх зүйн зөвлөгөө хэрэгтэй байгааг харуулж байна. Харин хуулийн салбарт ажиллагсад эрх зүйн зөвлөгөө хэрэгтэй гэж 32 орчим хувь нь, хуулийн зөвлөгөө хэрэгтэй гэж 56 орчим хувь нь үзжээ. Энэ нь хууль, эрх зүйн салбарт ажиллагсад хуулийн болон эрх зүйн зөвлөгөө ихээхэн шаардлагатай байгааг харуулж байна. Тиймээс энэ салбарын хүмүүсийн дунд давтан болон мэргэжил дээшлүүлэх сургалтууд зохион байгуулах, нэгдсэн мэдээллээр хангах ажлыг эрчимтэй явуулах хэрэгцээ өндөр байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

18. Харин судалгаанд оролцсон иргэдийн 7 орчим хувь нь захиргааны байгууллагын шийдвэрт гомдол гаргаж байжээ.

Иргэдийн аль байгууллагад гомдол гаргасныг дараахь хүснэгтээр авч үзье.

Хүснэгт 5.4. Гомдол гаргаж байсан захиргааны байгууллагууд

Байгууллагын нэр	Тоо	Судалгаанд оролцсон 850 иргэдтэй харьцуулсан хувь
Цагдаагийн газар	9	1.1
Шүүхэд	11	1.3
Прокурорт	2	0.2
Замын цагдаагийн газарт	2	0.2
Мэргэжлийн хяналтын газар	1	0.1
Хариулаагүй	34	4.0

Бүгд	59	6.9
------	----	-----

Эдгээр иргэдийн 4 орчим хувь нь гомдол гаргаад амжилт олсон бол 6 орчим хувь амжилт олоогүйгээр үл барам энэ нь надад муугаар нөлөөлсөн гэсэн бол 2 орчим нь амжилт олоогүй гэсэн байна. Хувийг судалгааны түүвэрт орсон 850 хүнтэй хувилан харьцуулсан болно. Харин хуулийн салбарт ажилладаг хүмүүсийн дунд захиргааны байгууллагын шийдвэрт гомдол гаргасан тохиолдол нэлээд цөөн буюу нийт судалгаанд хамрагдагсдын 8 гаруй хувь гомдол гаргаж байжээ. Гомдол гаргасан хүмүүс ажлаас хууль бусаар халсан шийдвэр, аймгийн засаг даргын шийдвэр, мэргэжлийн хяналтын алба, байгууллагынхаа дарга, нийслэлийн газрын алба, гаалийн байгууллага, шүүхийн ерөнхий зөвлөл зэрэгт ханджээ. Судалгаанд оролцсон 342 хүнээс 14 нь буюу 4.1 нь амжилт олсон бол 13 хүн нь буюу 3.8 хувь амжилт олоогүй байна. Эдгээр баримтуудаас үзэхэд хууль, эрх зүйн салбарт ажилладаг хүмүүсийн дунд захиргааны байгууллагын шийдвэрт гомдол гаргах нь цөөн байдаг нь харагдаж байна.

19. Албан газруудыг урд өмнөхөөсөө сайн ажиллаж байна гэж жирийн иргэдийн 3 гаруй хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 2 орчим хувь нь, ер нь тийм гэж жирийн иргэдийн 27 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 35 гаруй хувь нь үзсэн байхад бараг үгүй гэж жирийн иргэдийн 39 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 38 орчим хувь нь, огт үгүй гэж жирийн иргэдийн 9 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 9 гаруй хувь нь үзжээ. Энд бусад олон салбарт ажилладаг жирийн хүмүүс, хуулийн салбарт ажиллагсдын хариултуудын үр дүнд төдийлөн ялгаа байхгүй байна. Энэ нь албан газрууд урд өмнөхөөсөө муу ажиллаж байгааг илт харуулж байна. Судалгаанд оролцсон жирийн хүмүүсийн 17 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 24 орчим хувь нь өөрт холбогдох ямар нэг асуудлыг шүүхээр шийдвэрлүүлж байжээ.

20. Өөрийнхөө зөв гэдэгт бүрэн итгэлтэй байгаад шүүх үүнийг баталгаажуулна гэдэгт санаа зовдоггүй, би хуулийн байгууллага, шүүгч нарт бүрэн итгэдэг гэж жирийн иргэдийн 22 хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 21 гаруй хувь нь үзсэн байхад шүүх зуун хувь шударга шийдвэр гаргана гэдэгт бага зэрэг эргэлздэг гэж жирийн иргэдийн 33 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 37 орчим хувь нь, тухайн шүүгч болон прокуророос их зүйл хамаардаг учраас нэлээд их эргэлздэг гэж жирийн иргэдийн 29 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 36.0 хувь нь хариулжээ. Эндээс үзвэл нийт ард олон болоод хуулийн салбарт ажиллагсдын дунд шүүхэд итгэх итгэл сул байгаа нь харагдаж байна.

21. Шүүхэд очилгүй талуудыг хооронд нь эвлэрүүлэх, зөвлөгөө өгөх газруудын үүргийг чухал гэж жирийн иргэдийн 60 гаруй хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 82 орчим хувь нь хариулсан нь шүүхэд очилгүй талуудыг эвлэрүүлэх, зөвлөгөө өгөх газрууд шаардлагатайг харуулж байгаа бөгөөд хуулийн салбарт ажилладаг хүмүүс маш идэвхтэй дэмжиж ажиллах нь илэрхий байна.

22. Шүүх болон шүүгч нар шийдвэр гаргах эрхээ шударга ёсны төлөө ашигладаг гэдэгт итгэдэг гэж судалгаанд оролцсон жирийн хүмүүсийн 27 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 26 орчим хувь нь илэрхийлсэн бол гарч болохуйц бүхий л зөрчилдөөнийг хууль тогтоогч зохицуулж өгөх ёстой. Ингэснээрээ шүүгчдийн шийдвэр гаргах эрх чөлөөг багасгах юм гэж жирийн иргэдийн 41 гаруй хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 50 гаруй хувь нь үзсэн байна. Эндээс шүүгчдийн эрхийг багасгах, хуулиудын зүйл, заалтуудыг нарийсгаж, шүүх болон шүүгчдийн эрхийг хуулиар хязгаарлах хэрэгтэй нь харагдаж байгаа бөгөөд үүний цаана шүүх, шүүгчдэд итгэх итгэл сул байгаа нь ажиглагдаж байна.

23. Судалгаанд оролцсон жирийн иргэдийн 82 гаруй хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 94 гаруй хувь нь бидэнд эрх зүй, хууль заавал хэрэгтэй гэж хариулсан нь хууль, эрх зүй нийгэмд зайлшгүй хэрэгтэй, үнэ цэнэтэй байгааг илэрхийлж байна.

24. УИХ-аар дамжуулан төрийн эрхийг барих Үндсэн хуулийн эрхээ эдэлж байгаа талаар судалгаанд оролцогчид УИХ дахь өөрийн сонгосон төлөөлөгчдөө сэтгэл хангалуун гэж жирийн иргэдийн 29 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 27 орчим хувь нь үзсэн байхад хангалуун бус гэж жирийн иргэдийн 46 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 46 гаруй хувь нь үзсэн бол УИХ-аас иргэдийн сэтгэлд нийцдэггүй хууль батлан гаргадаг гэдэгтэй жирийн иргэдийн 44 гаруй хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 59 орчим хувь нь санал нийлж, жирийн иргэдийн 15 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 24 орчим хувь нь эсрэг байр суурьтай байгаагаа илэрхийлжээ.

УИХ буюу УИХ-ын гишүүд бидэнд үүрэг ногдуулахаас бус бидний эрхийн талаар санаа тавьдаггүй гэсэн хариултыг иргэдийн 54 гаруй хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 63 орчим хувь нь үнэн, иргэдийн 15 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 22 хувь нь худлаа гэж хариулсан байна. Харин УИХ-ын гишүүд жирийн иргэдийн бодол санаа, хүсэл зоригт их анхаарал тавьдаг гэсэн хариултыг иргэдийн 11 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 21 гаруй хувь нь үнэн, иргэдийн 65 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 59 орчим хувь нь худлаа гэжээ. Хууль хэрхэн батлагдан гарсныг жирийн иргэд ойлгодоггүй гэдэгтэй иргэдийн 65 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 83 орчим хувь нь санал нийлсэн бол иргэдийн 11 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 9 хувь нь санал нийлээгүй байна.

Монгол Улсын эрх зүйн бүтцийг би дараахь байдлаар тодорхойлж чадна. Би ч гэсэн хуулийг яг адилхнаар батлан гаргах байсан гэж 27 гаруй хувь нь хариулсан бол худлаа гэж 21 гаруй хувь нь, хэлж мэдэхгүй гэж 42 орчим хувь үзсэн байна. Энэ нь хуулийн байгууллагад ажиллагсдын дийлэнхи нь өнөөгийн эрх зүйн бүтэц, батлагдан гарч буй хуулиудын талаар тогтсон байр суурьгүй байгаа нь харагдаж байна. Магадгүй хэр сайн хууль болсныг олон жилийн амьдралын туршлага ч харуулдаг байж болох юм.

Эрх зүйн тогтолцоо тодорхой ач холбогдолтой байх талаар төрийн зүгээс их анхаардаг гэсэн хариултыг үнэн гэж иргэдийн 26 орчим хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 51 гаруй хувь нь дэмжсэн бол худлаа хэмээн иргэдийн 32 орчим хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 14 орчим хувь нь дэмжээгүй байна. Дээрхи асуудал нь хуулийн салбарт ажиллагсдын хувьд бол бараг ажил, үүргийг нь үнэлсэн хэрэг байсан учир үр дүнг нь нийгмийн бусад хэсэгтэй харьцуулахад хол зөрөөтэй гарчээ.

25. Хуулийн салбарт ажиллагсдаас “эрх зүй” хэмээх ухагдахуунтай Монголын практик амьдралд хамгийн их нягт холбоотой дараахь 14 сонголтоос сонго гэсэн асуултаас хэрхэн сонгосныг хувиар авч үзвэл:

Шударга ёс-25.1, Олон нийтийн аюулгүй байдал-7.1, Эрх чөлөө-17.3, Хэв журам-6.1, Захиргааны албан газрууд-3.8, Шүүх-7.1, Цагдаа-3.3, Эрх зүйн аюулгүй байдал-7.7, Адил тэгш байх зарчим-15.8, Зөрчлийг шийдэх-4.8, Албадлага-0.9, Ухаан мэдрэл алдсан мэт байдал-0.2, мэдэхгүй-0.2 хувийг тус тус эзэлж байна.

26. Судалгаанд оролцсон жирийн хүмүүс дараахь ойлголтуудаас “эрх зүй”-тэй холбон ойлгох ёстой гэж үзсэнээ сонгосныг давхардсан тоо, хувь, давхардсан хувийн хамтаар хүснэгтээр үзье.

Хүснэгт 5.5. Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтууд

Өгөгдсөн сонголтууд	Давхардсан тоо	Хувь	Давхардсан хувь
Шударга ёс	567	24.9	71.2
Олон нийтийн аюулгүй байдал	194	8.5	24.4
Эрх чөлөө	327	14.3	41.1
Хэв журам	227	10.0	28.5
Захирааны албан газрууд	79	3.5	9.9
Шүүх	148	6.5	18.6
Цагдаа	79	3.5	9.9
Эрх зүйн аюулгүй байдал	200	8.8	25.1
Адил тэгш байх зарчим	302	13.2	37.9
Зөрчлийг шийдэх	81	3.6	10.2
Бусдын гарт орсон мэт байх	20	0.9	2.5
Албадлага	22	1.0	2.8
Ухаан мэдрэл алдсан мэт байдал	12	0.5	1.5
Мэдэхгүй	22	1.0	2.8
Бүгд	2280	100%	286.4%

Хүснэгтээс үзвэл хүмүүс шударга ёс, эрх чөлөө, тэгш эрх зэрэг ардчилал, хүний эрхийн тулгуур ойлголтуудыг түлхүү сонгосон нь харагдаж байгаа бөгөөд энэ нь манай улсад эдгээр зарчмуудыг муу хуульчилсан, хуульд тусгасан ч амьдралд хэрэгждэггүйг харуулж байна.

Харин одоо хуулийн салбарт ажиллагсдын сонгосныг давхардсан тоо, хувь, давхардсан хувийн хамт хүснэгтээр үзүүлье.

Хүснэгт 5.6. Эрх зүйтэй холбон ойлгох ёстой ойлголтууд

Өгөгдсөн сонголтууд	Давхардсан тоо	Хувь	Давхардсан хувь
Шударга ёс	192	24.2	71.4
Олон нийтийн аюулгүй байдал	55	6.9	20.4
Эрх чөлөө	123	15.5	45.7
Хэв журам	46	5.8	17.1
Захиргааны албан газрууд	28	3.5	10.4
Шүүх	60	7.6	22.3
Цагдаа	31	3.9	11.5
Эрх зүйн аюулгүй байдал	82	10.4	30.5
Адил тэгш байх зарчим	121	15.3	45.0
Зөрчлийг шийдэх	42	5.3	15.6
Бусдын гарт орсон мэт байх	2	0.3	0.7
Албадлага	9	1.1	3.3
Ухаан мэдрэл алдсан мэт байдал	1	0.1	0.4
Бүгд	792	100%	294.4

Хувиудын зөрөө бага нь энэхүү үр дүн нь дээрхи дүгнэлтийг давхар баталж байна.

27. Бусад хүмүүстэй ямагт шударга харьцах нь өөрт эерэг нөлөөтэй гэж иргэдийн 36 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 40 гаруй хувь нь, ихэнхдээ тэнэг байдалд оруулдаг гэж иргэдийн 12 хувь, хуулийн салбарт ажиллагсдын 11 орчим хувь нь, янз бүр гэж иргэдийн 42 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 42 гаруй хувь нь хариулжээ. Үүнээс үзвэл Монголын нийгэм, хүн ард шударга ёсыг эрхэмлэн дээдэлсээр байгаа боловч тодорхой хэсэг нь шударга байхаас татгалздаг, нэлээд нь тухайн нөхцөл байдлаас хамаарч шударга байх зарчмыг баримталдаг байна.

28. Захиргааны хэргийн шүүх нь надад эергээр нөлөөлнө гэж иргэдийн 39 гаруй хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 50 орчим хувь нь, захиргааны албан хаагч эсхүл захиргааны байгууллагын шийдвэрт гомдол гаргах нь эцэстээ надад сөрөг үр дагавар авчирна гэж иргэдийн 19 орчим хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 7 гаруй хувь нь, надад ямар ч нөлөө байхгүй гэж иргэдийн 15 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 22 орчим хувь нь, мэдэхгүй гэж иргэдийн 22 орчим хувь нь, хуулийн салбарт ажиллагсдын 13 орчим хувь нь үзсэнээс харахад Монголд шинээр байгуулагдсан захиргааны хэргийн шүүхийн талаар судалгаанд оролцогчид нааштай хандаж, дэмжиж байгаа нь илт бөгөөд захиргааны хэргийн шүүхийн талаарх ард олны ойлголт сайн байгаа, хүмүүс захиргааны хэргийн шүүхийн талаар тодорхой ойлголттой болсныг харуулж байна.

29. Судалгаанд оролцсон хуулийн салбарт ажиллагсдаас сонгуульд тогтмол оролцдог, сонгуулийг өнгөрөөхгүйг боддог гэж 25 орчим хувь, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцдог хэмээн 21 орчим хувь, улс төрд их сонирхолтой гэж 2 гаруй хувь, найз нөхөд танилуудтайгаа улс төрийн тухай их ярилцдаг гэж 20 орчим хувь, зөв гэсэн итгэл үнэмшилтэй бол улс төрийн жагсаал цуглаанд оролцоно гэж 25 гаруй хувь нь хариулжээ. Нийгмийн идэвхтэй холбоотой эдгээр сонголтуудыг жигдхэн сонгосон нь хуулийн салбарт ажиллагсдын нийгэм, улс төрийн идэвхи өндөр байдаг нь харагдаж байна.

30. Хамгийн сүүлийн УИХ-ын сонгуульд иргэдийн 78 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 84 орчим хувь нь, Ерөнхийлөгчийн сонгуульд иргэдийн 65 орчим хувь, хуулийн салбарт ажиллагсдын 82 орчим хувь нь, орон нутгийн сонгуульд иргэдийн 55 гаруй хувь, хуулийн салбарт ажиллагсдын 56 орчим хувь нь оролцсон мэдээ гарсан нь судалгаанд хамрагдсан хүмүүсийн нийгмийн болон улс төрийн идэвхи өндөр байгааг харуулах бөгөөд хуулийн салбарт ажиллагсдын дунд сонгуулийн идэвхи өндөр байдаг нь харагдаж байна. Харин орон нутгийн сонгуулийн тухайд жирийн иргэд, хуулийн салбарт ажиллагсад ялгаагүй УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийг бодвол тийм ч их ач холбогдол өгдөггүй нь харагдаж байна.